гүйлгээ хийх үйл ажиллагааны салбар ( 3.5 дахин ) зэрэг салбаруудад гарсан нь Зураг-10 –аас харагдаж байна. Эдгээр салбаруудын 1995-2009 оны нэмэгдэл өртгийн өсөлт ДНБ –ний өсөлтөөс ихээхэн өндөр байжээ. Үүнээс гадна уул уурхайн салбарын нэмэгдэл өртөг 1995-2009 оны хооронд 2.1 дахин, бөөний болон жижиглэн худалдааны салбарынх 2.1 дахин буюу ДНБ –ний өсөлтөөс давсан өссөлттэй байв.

**Зураг-10. 1995-2009 онд ДНБ –ний өсөлтөөс өндөр өсөлттэй байсан салбарууд,хувиар**




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Харин хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамжийн салбар, боловсрол, барилгын салбаруудын нэмэгдэл өртөг 1995-2009 онд ДНБ-ний өсөлтөөс бага хурдтай нэмэгдсэн нь Зураг-11- ээс харагдаж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн өсөлт 2002-2008 онд ДНБ –ний өсөлтөөс түрүүлж байсан боловч 2009 онд эрс буурсн байна.

**Зураг-11. 1995-2009 онд ДНБ –ний өсөлтөөс доогуур өсөлттэй байсан салбарууд**




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Гол салбаруудын эдийн засгийн бодит өсөлтийг тухайн салбар бүрийн биет хэмжээний гол үзүүлэлтүүдийн өсөлтөөр Хүснэгт -3 –д харуулав.

**Хүснэгт-3. Салбаруудын биет хэмжээний гол үзүүлэлтүүдийн өсөлт**

| Natural Indicators | 1995 | 2000 | 2005 | 2009 | 2009/1995% |
|---|---|---|---|---|---|
| **1.Хөдөө аж ахуй** | | | | | |
| 1.1 Малын тоо,мян. толгой | 28572.3 | 30227.5 | 30398.8 | 44023.9 | 540.1 |
| 1.2 Хураан авсан ургац, мянган тонн: | | | | | |
| -Үр тариа | 261.4 | 142.1 | 75.5 | 391.7 | 149.8 |
| -Хүнсний ногоо | 27.3 | 44.0 | 64.2 | 78.0 | 285.7 |
| - Төмс | 52.0 | 58.9 | 82.8 | 151.2 | 290.8 |
| **2.Уул уурхайн олборлох үйлдвэр,** | | | | | |
| - олборлосон нүүрс, мян.тн | 5019.0 | 5185.0 | 7517.1 | 14442.1 | 287.7 |
| -зэсийн баяжмал,-“- | 346.4 | 357.8 | 361.6 | 370.9 | 107.0 |
| -алт олборлолт, кг | 4504.0 | 11808.1 | 24121.9 | 9803.3 | 217.6 |
| -Газрын тос,мян.баррель | - | - | 200.7 | 1870.0 | - |
| **3.Öàõèëãààí, äóëààíû ¿éëäâýðëý, óñàí õàíãàìæ** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| - цахилгаан эрчим хүч, сая кВт.цаг<br>-дулааны эрчим хүч,мян.гкал | 2628.0<br><br>6816.8 | 2946.0<br><br>6885.4 | 3418.9<br><br>7805.6 | 4038.8<br><br>8320.5 | 153.7<br><br>122./1 |
| **4. Тээвэр, холбоо**<br>- Тээсэн ачаа, мян. Тонн<br>- Үүрэн телефон хэрэглэгчийн тоо (давхардсан тоогоор), мян.ш | <br>8950.8<br><br>0.0 | <br>10643.4<br><br>75.1 | <br>23670.4<br><br>570.9 | <br>24736.7<br><br>2208.7 | <br>276.4<br><br>- |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Салбаруудын биет хэмжээний гол үзүүлэлтүүдийн өсөлт ч нэлээд өндөр гарсан байна. Ялангуяа холбооны салбарт үүрэн телефон хэрэглэгчдийн тоо давхагдсан тоогоор 2000 онд дөнгөж 75.1 мянга байсан бол 2009 онд 2,2 саяд хүрсэн нь энэн салбарын үсрэнгүй хурдан хөгжлийг илтгэж байна.

### 6. Эдийн засгийн өсөлтөд нөлөөлсөн зарим хүчин зүйлс

Онолын хувьд улс орны эдийн засгийн өсөлтөнд олон хүчин зүйлс нөлөөлдгийг дээр бид авч үзсэн. Эдгээрээс эдийн засгийн өсөлтийн шинжилгээнд ажиллах хүч, капиталын хэмжээ, хөдөлмөрийн бүтээжийн дээшлэлтийг гол хүчин зүйлс болгон ихэвчлэн судалдаг.

Эдийн засгийн өсөлтөд ажиллах хүч, капиталын хэмжээ хэрхэн нөлөөлснийг тооцохыг судалгааны бүтээлүүдэд “Өсөлтийн тооцоо” ( Growth Accounting) буюу манай оронд үйлдвэрлэлийн функцээр тооцох гэдэг. Энэхүү аргаар эдийн засгийн өсөлтийг бий болгохд ажиллах хүч болон капитал ямар хувь нэмэр оруулсныг шинжилдэг. Эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн дээрх хүчин зүйлсийн хамаарлыг үйлдвэрлэлийн агрегат функцээр илэрхийлдэг.

$$Y_t = A_t K_t^{\alpha} L_t^{\beta}$$

Энд: $Y_t$ -ДНБ, $A_t$ - бүтээмжийн хүчин зүйл, $K_t^{\alpha}$ - капиталын хэмжээ, $L_t^{\beta}$ - ажиллах хүчний хэмжээ.

Энэхүү үйлдвэрлэлийн агрегат функц нь t – гэсэн хугацаанд үйлдвэрлэлийн 2 хүчин зүйл болох капитал, ажиллах хүчийг бүтээмжийн нэгдсэн хүчин зүйл (А ) болгон нэгтгэн үйлдвэрлэлийн эцсийн үр дүн болох ДНБ –тэй холбож өгдөг. Энд А гэсэн коэффициент нь

капитал, ажиллах хүчээр үл тайлбарлагдах бусад хүчин зүйлийн нөлөөг илэрхийлдэг бөгөөд энэ ьн технологийн дэвшил, нийт бүтээмжийн нөлөө гэж үздэг.

Манай орны хувьд ажиллах хүчний хэмжээг нийт ажиллагсдын тоогоор хялбархан илэрхийлж болдог бол харин капиталын хэмжээг харуулсан мэдээлэл байдаггүйгээс өөр үзүүлэлтээр орлуулан тооцоход хүрдэг. Энэхүү судалгаанд капиталын хэмжээг ДНБ –ний тооцоонд орсон үндсэн капиталын хэрэглээ болох үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрөнгө оруулалт хоёрын аль нэгнээр орлуулан авах арга байсан. Гэвч үндсэн хөрөнгийн элэгдэлийн үндсэн капиталыг орлуулан авахад гарсан үр дүн статистикийн хувьд ач холбогдол багатай гарсан тул хөрөнгө оруулалтыг орлуулан авлаа. Уг нь тухайн жилийн хөрөнгө оруулалтын ихэнх нь үндсэн хөрөнгө болон хувирдаг гэсэн агуулгаар үндсэн капиталыг орлуулсан боловч өмнөх үеүдэд хуримтлагдсан капиталын хэмжээг тусгаагүй тул учир дутагдалтай нь мэдээж билээ.

Бид энэхүү судалгаанд дараахь өгөгдлүүдийг ашиглав. Үүнд:

$Y_t$ - ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээр /сая.төг/, t= 1990-2009

I - Нийт хөрөнгө оруулалт,2005 оны зэрэгцүүлэх үнээр, /сая.төг/

L- Ажиллагчдын тоо, /мянган хүн/

Хөрөнгө оруулалтыг 2005 оны зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ барилгын салбарын нэмэгдэл өртгийг 2005 оны үнэд шилжүүлсэн дефляторыг ашиглав.

Кобб-Дугласын үйлдвэрлэлийн функцыг шугаман хэлбэрт оруулан хувиргахад:

$$LogY = A + \alpha \cdot LogI + \beta \cdot LogL$$ болдог.

E-View-9 программаар тооцсон үр дүн дараахь байдлаар гарав.

**Хүснэгт-4. Регрессийн хамаарлын үр дүн**

Dependent Variable: Log Y

Method: Least Squares

Date: 09/15/10 Time: 12:51

Sample: 1990 2009

Included observations: 20

| | Coefficient | Std. Error | t-Statistic | Prob. |
|---|---|---|---|---|
| A | 1.109592 | 0.572509 | 1.938123 | 0.0694 |
| Log I | 0.207219 | 0.078338 | 2.645185 | 0.0170 |
| Log L | 1.383036 | 0.322228 | 4.292099 | 0.0005 |

| | | | |
|---|---|---|---|
| R-squared | 0.938134 | Mean dependent var | 6.355642 |
| Adjusted R-squared | 0.930856 | S.D. dependent var | 0.104702 |
| S.E. of regression | 0.027532 | Akaike info criterion | -4.209484 |
| Sum squared resid | 0.012886 | Schwarz criterion | -4.060124 |
| Log likelihood | 45.09484 | Hannan-Quinn criter. | -4.180327 |
| F-statistic | 128.8942 | Durbin-Watson stat | 0.739900 |
| Prob(F-statistic) | 0.000000 | | |

Хүснэгтийн үзүүлэлтүүдээс үйлдвэрлэлийн функцийн шугаман хэлбэрт оруулсан утгыг орлуулбал:

$LogY = 1.11 + 0.207 \cdot LogI + 1.383 \cdot LogL$ болно.

Log I, Log L үл хамааран хувьсагчид нь 95%-ийн магадлалтайгаар ач холбогдолтой, Сул гишүүн A нь 90%-ийн магадлалын түвшинд ач холбогдолтой гарсан байна.

Хүснэгтээс детерминацын коэффициент 0,93 гарсан нь эдийн засгийн өсөлтийн 93 хувийг ажиллах хүч, хөрөнгө оруулалтын хүчин зүйлээр тайлбарлаж болно гэсэн үг билээ. Харин гарсан үр дүнгээс харахад хөрөнгө оруулалтын цэвэр өсөлтийн 1% -д ДНБ –ний цэвэр өсөлтийн 0.2 хувь, харин ажиллагсдын тооны цэвэр өсөлтийн 1% -д ДНБ –ний хэмжээ илүү мэдрэмжтэй,нөлөөтэй байгаа бөгөөд ДНБ –ний 1.38 хувийн цэвэр өсөлт харгалзаж байна. Капиталын оронд хөрөнгө оруулалтыг авсанаар түүний үзүүлэх нөлөө ДНБ –ний өсөлтөнд харьцангуй бага гарсан байна. Харин сул гишүүн A нь 1.11 гарсан нь техникийн дэвшил, бүтээмж ихээхэн нөлөөтэй байсныг харуулав.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд ажиллагсдын тоо, хөдөлмөрийн бүтээмж хэрхэн нөлөөлснийг авч үзье. Энэ нь эдийн засгийн өсөлтийг экстэнсив буюу ажиллагсдын тооны өсөлтөөр болон интенсив арга замаар буюу хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээр хэрхэн хангасныг харуулах болно.

Бид энд индексийн аргыг ашиглав. ДНБ-ний өсөлтийн индексыг хөдөлмөрийн бүтээмж болон ажиллагсдын тооны өсөлтийн индексын үржвэрээр дараах байдлаар илэрхийлж болно.

$$GDP = GDP_W * GDP_T$$

Энд: GDPw- хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс бий болсон ДНБ –ний өсөлт

GDPт – ажиллагсдын тооны өсөлтөөс бий болсон ДНБ –ний өсөлт

Хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс бий болсон ДНБ –ний өсөлт дараахь индексээр илэрхийлэгдэнэ.

$$GDP_W = \frac{W_1 T_1}{W_0 T_1}$$

Энд: Wo болон W1 суурь болон тайлант оны хөдөлмөрийн бүтээмжийг түвшин. Т- ажиллгсдын тоо.

Ажиллагсдын тооны өсөлтөөс бий болсон ДНБ –ний өсөлт дараахь индексээр илэрхийлэгдэнэ. $GDP_T = \frac{T_1 W_0}{T_0 W_0}$

Эдгээрийг үндэслээд хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс бий болсон ДНБ –ний абсалют өсөлтийн хэмжээг дараах байдлаар тооцсон.

$$\Delta W = W_1 T_1 - W_0 T_1$$

Харин ажиллагсдын тооны өсөлтөөс бий болсон ДНБ –ний абсалют өсөлтийн хэмжээг дараах байдлаар тооцов.

$$\Delta T = T_1 W_0 - T_0 W_0$$

1990 болон 2009 оны ажиллагсдын тоо, хөдөлмөрийн бүтээмжийн түвшинг үндэслэн дээрх зөрүүг тооцоход дараах байдалтай гарлаа.

$\Delta W$ = 1146409.8 сая төгрөг, $\Delta T$ = 562283,3 сая төгрөг

Хүснэгт -5 –д 1995-2009 оны хооронд ДНБ –ний жил бүрийн абсалют цэвэр өсөлтийн хичнээн хувийг дээрх 2 хүчин зүйлээр хангасныг харуулав.

**Хүснэгт-5. ДНБ-ний өсөлтөд ажиллагсдын тоо, хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлсэн нөлөөлөл**

| | ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээр,сая төг. | Ажиллагсдын тоо,мянган хүн | Хөдөлмөрийн бүтээмж, мянган төг. | Ажиллагсдын тооноос бий болсон өсөлт, сая төг. | Хөдөлмөрийн бүтээмжээс бий болсон өсөлт, сая төг. | ДНБ-ний абсалют цэвэр өсөлт, сая төг. |
|---|---|---|---|---|---|---|
| 1990 | 1855585 | 783.6 | 2368.0 | | | |
| 1991 | 1750556.5 | 795.7 | 2200.0 | 28653.1 | -133681.6 | -105028.5 |
| 1992 | 1655501.5 | 806.0 | 2054.0 | 22660.2 | -117715.2 | -95055 |
| 1993 | 1584155.7 | 772.8 | 2049.9 | -68191.9 | -3153.9 | -71345.8 |
| 1994 | 1631338.3 | 786.5 | 2074.2 | 28083.5 | 19099.1 | 47182.6 |
| 1995 | 1699160.6 | 794.7 | 2138.1 | 17008.2 | 50814.1 | 67822.3 |
| 1996 | 1747007.7 | 791.8 | 2206.4 | -6200.5 | 54047.6 | 47847.1 |
| 1997 | 1822383.3 | 788.3 | 2311.8 | -7722.3 | 83097.9 | 75375.6 |
| 1998 | 1909739.4 | 809.5 | 2359.2 | 49009.9 | 38346.2 | 87356.1 |
| 1999 | 2004471.4 | 813.6 | 2463.7 | 9672.6 | 85059.4 | 94732 |
| 2000 | 2030430.2 | 809 | 2509.8 | -11333.0 | 37291.8 | 25958.8 |
| 2001 | 2090382.9 | 832.3 | 2511.6 | 58478.4 | 1474.3 | 59952.7 |
| 2002 | 2189320.3 | 870.8 | 2514.1 | 96695.6 | 2241.8 | 98937.4 |
| 2003 | 2342674.1 | 923.5 | 2536.7 | 132495.6 | 20858.2 | 153353.8 |
| 2004 | 2591592.8 | 950.5 | 2726.6 | 68491.8 | 180426.9 | 248918.7 |
| 2005 | 2779578.3 | 968.3 | 2870.6 | 48532.7 | 139452.8 | 187985.5 |
| 2006 | 3017425.8 | 1009.9 | 2987.8 | 119415.9 | 118431.6 | 237847.5 |
| 2007 | 3325892.5 | 1024.1 | 3247.6 | 42427.4 | 266039.3 | 308466.7 |
| 2008 | 3622670.5 | 1041.2 | 3479.3 | 55534.4 | 241243.6 | 296778 |
| 2009 | 3564278.1 | 1006.3 | 3542.0 | -121428.4 | 63036.0 | -58392.4 |
| 2010 | 4 153 972.8 | | | | | |
| ДҮН | 43358559.9 | - | - | 562283.3 | 1146409.8 | 1708693.1 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

1990-2009 оны хооронд ДНБ –ний абсалют цэвэр өсөлт 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1708.7 тэрбум төгрөг болсныг Хүснэгт-5 –аас харж болно. Үүний 1146.4 тэрбум төгрөг буюу 67.1 % нь хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс, 562,3 тэрбум төгрөг буюу 32.9 % нь ажиллагсдын тооны өсөлтөөр бий болсон байна. Эндээс харахад 1990-2009 оны хооронд эдийн засгийн өсөлтийн 2/3 нь интенсив арга замаар буюу хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс бий болжээ.

**7. Эдийн засгийн өсөлт ба хүн амын ажил эрхлэлт**

Хүний хөгжлийн үзэл баримтлалд зааснаар эдийн засгийн өсөлт нь хөгжлийг хангах зайлшгүй шаардлагатай нөхцөл юм. Гэхдээ эдийн засгийн өсөлт нь шууд ядуурлыг бууруулж, ард түмний амьдралыг сайжруулж чаддаггүй ажээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллага Мянганы Хөгжлийн Зорилтуудын нэгдүгээр зорилт болох ядуурлыг бууруулах зорилтыг хангахын тулд " ажил хийснээр ядуурлаас гарах " аргыг дэмжин сурталчилдаг. Олон улсын туршлагаас харахад эдийн засгийн эрчимтэй өсөлт нь зөвхөн зохистой хөдөлмөрөөр дамжин ядуурлыг бууруулдаг бөгөөд энэ нь бүтээмж өндөртэй ажлын байр шинээр бий болгосноор хэрэгждэг байна. Өөрөөр хэлбэл, зохистой хөдөлмөр эрхлэлт нь ядуу хүмүүсийн хувьд өөрийн ганц өмч болох хөдөлмөрлөх хүчээ дээд зэргээр ашиглах боломжийг олгодог байна. Ядуу хүмүүсийг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оролцуулах нь эдийн засгийн өсөлтийг бий болгоод зогсохгүй, ядуурлыг бууруулах арга зам болдог ажээ. Гэтэл манай орны практикт ядуу хүмүүс хөдөлмөр эрхлэхэд олон хүндрэл бэрхшээл учирдаг нь өмнө хийгдсэн ажил эрхлэлтийн судалгаа болон практикаас тодорхой байдаг. Хамгийн эхний хүндрэл нь тодорхой мэргэжил, боловсролгүйгээс ядуу хүмүүс тухайн ажлын байранд ажиллах боломжгүй шууд гологддог. Ажлын байр зарим хэмжээгээр байгаа боловч энэ шалтгаанаар хүмүүүс тэр дотроо ядуу хүмүүс ажиллах боломжгүй байдаг. Манай орны хувьд хот, суурин газарт амьдардаг ядуу хүмүүсийн олонх нь хөдөөнөөс нүүж ирсэн, урьд өмнө нь мал маллахаас өөр ажил эрхэлж байгаагүй, тодорхой мэргэжилгүй хүмүүс байдаг тул мэргэжил шаардсан ажлын байранд ажиллах боломжгүй байна. Манай орны онцлогтой хоёр дахь гол шалтгаан нь ядуу хүмүүс нь шилжилтийн үед ажилгүй болсон, ихэвчлэн ажил эрхлээгүй олон жил болсон, ялангуяа эрэгтэйчүүд нь архинд орсон, "зэвэрсэн" гэж нэрлэж болох хүмүүс байдаг. Ийм хүмүүс ажилд орсон ч цагаар тогтмол ажил эрхэлж сураагүй, ажил тасалж, архи уудаг, хөдөлмөрийн сахилга баримталдаггүй зэргээсээ болоод ажлаас халагддаг. Ийм байдлаар ажил эрхлэхгүй байгаа хүмүүсийн жишээ амьдралаас олноороо олддог. Гуравдагч шалтгаан нь цалин хөлсний хэмжээ багатай холбоотой байдаг. Энэ хүчин зүйл залуучуудад их нөлөөтэй байдаг. Бага цалинтай ажил эрхлэх залуу хүмүүс ховор бөгөөд тэд ихэвчлэн гадаадад гарч хөдөлмөрөө үнэлэх хүсэл сонирхотой байдаг. Хүн ам, орон сууцны тооллого болон ажиллах хүчний судалгааны асуултад эдгээр хүмүүс ихэвчлэн " тохирох ажил

олдоогүй” гэсэн хариултыг сонгодог. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр тохирох ажил олдоогүй гэж 90 мянган хүн хариулсан байдаг.

Өмнөх хэсэгт бид 1990-2009 оны хооронд ДНБ-ний цэвэр өсөлтийн 32,9 хувийг ажиллагсдын тооны өсөлтөөр хангасныг тооцож харуулсан. Хүн амын ажил эрхлэлт эдийн засгийн өсөлтөнд тодорхой нөлөө үзүүлдэгийг нотолсон.

**Хүснэгт-6. ДНБ болон ажиллагсдын тоо, түүний өслт**

| | ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээх, сая төгрөг | Ажиллагсдын тоо, мянган хүнээр | ДНБ-ний өсөлт, 1990=1 | Ажиллагсдын тооны өсөлт, 1990=1 |
|---|---|---|---|---|
| 1990 | 1,855,585.0 | 783.6 | 1 | 1 |
| 1991 | 1,750,556.5 | 795.7 | 0.943 | 1.015 |
| 1992 | 1,655,501.5 | 806.0 | 0.892 | 1.029 |
| 1993 | 1,584,155.7 | 772.8 | 0.854 | 0.986 |
| 1994 | 1,631,338.3 | 786.5 | 0.879 | 1.004 |
| 1995 | 1699160.6 | 794.7 | 0.916 | 1.014 |
| 1996 | 1747007.7 | 791.8 | 0.941 | 1.010 |
| 1997 | 1822383.3 | 788.3 | 0.982 | 1.006 |
| 1998 | 1909739.4 | 809.5 | 1.029 | 1.033 |
| 1999 | 2004471.4 | 813.6 | 1.080 | 1.038 |
| 2000 | 2030430.2 | 809 | 1.094 | 1.032 |
| 2001 | 2090382.9 | 832.3 | 1.127 | 1.062 |
| 2002 | 2189320.3 | 870.8 | 1.180 | 1.111 |
| 2003 | 2342674.1 | 923.5 | 1.262 | 1.179 |
| 2004 | 2591592.8 | 950.5 | 1.397 | 1.213 |
| 2005 | 2779578.3 | 968.3 | 1.498 | 1.236 |
| 2006 | 3017425.8 | 1009.9 | 1.626 | 1.289 |
| 2007 | 3325892.5 | 1024.1 | 1.792 | 1.307 |
| 2008 | 3622670.5 | 1041.2 | 1.952 | 1.329 |
| 2009 | 3564278.1 | 1006.3 | 1.921 | 1.284 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Хүснэгтээс харахад ДНБ ажиллагсдын тооноос илүү хурдан нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж дээшилжээ. Ялангуяа 2004 оноос эхэлж, ДНБ –ний өсөлт ажиллагсдын тооныхоос илүү хурдацтай нэмэгдсэн нь Зураг-12- оос харагдаж байна.

**Зураг-12. ДНБ болон ажиллагсдын тооны өсөлт, 1990=1**




ДНБ болон ажиллагсдын тооны хоорондын хамраалыг зегрессийн шинжилгээний аргаар шалгаж үзье:

**Зураг-13. ДНБ болон ажиллагсдын тооны өсөлтийн хамаарлын тархалтын цэгүүд**




Цэгүүд регрессийн шугамын төгсгөл дээр бөөгнөрөх хандлагатай гарсан. STATA программаар хийсэн үр дүнг доор харуулав.

```
      Source |       SS       df       MS              Number of obs =      20
-------------+------------------------------           F(  1,    10) =    4.98
       Model |  23.1071238     1  23.1071238           Prob > F      =  0.0497
    Residual |   46.409544    10   4.6409544           R-squared     =  0.3324
-------------+------------------------------           Adj R-squared =  0.2656
       Total |  69.5166678    11  6.31969707           Root MSE      =  2.1543
------------------------------------------------------------------------------
       empld |      Coef.   Std. Err.      t    P>|t|     [95% Conf. Interval]
-------------+----------------------------------------------------------------
      gr_gdp |   .3934913   .1763461     2.23   0.050     .0005677    .7864149
       _cons |  -.2054746   1.199542    -0.17   0.867    -2.878222    2.467273
------------------------------------------------------------------------------
```

Үр дүнгийн гарсан өгөгдлүүдээр ДНБ болон ажиллагсдын хоорондын хамаарлыг дараах шугаман тэгшитгэлээр илэрхийлж болно.

GR_EMP= -0.21 + 0.39 GR_GDP $R^2 = 0.332$

Юуны өмнө ДНБ болон ажиллагсдын тооны хооронд хүчтэй хамааралгүй, хамаарлын хүч нь сулавтар байгааг 0,332 гэсэн коэффициент харууллаа.

Тэгшитгэлээс ДНБ 0.39 хувь өсөхөд ажиллагсдын тоо 1 хувиар нэмэгдэхээр байна.

## 8. Хүн амын ядуурлын төлөв байдал, түүний чиг хандлага

1990 оноос хойш Монголд нүүрлэсэн нийгмийн шийдвэрлэгдээгүй хурц асуудал нь хүн амын ядуурал билээ. Ядуурлын шугамыг сонгосон байдал, түүвэрлэлтийн хэмжээ зэргээрээ өмнөх онуудад хийгдсэн ядуурлын судалгаануудын үр дүнг шууд харьцуулах боломгүй гэж үздэг хэдий боловч ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийн ерөнхий чиг хандлагыг дараахь хүснэгт, зургаас харж болно.

**Хүснэгт-7. Хүн амын ядуурлын түвшин, хувиар**

| | ßäóóðëûí ò¿âøèí,% | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1995 | 1998 | 2002-2003 | 2006 | 2007-2008 | 2009 |
| Óëñûí ä¿í | 36.3 | 35.6 | 36.1 | 32.2 | 35.2 | 38.7 |
| õîò | 38.5 | 39.4 | 30.3 | 27.9 | 26.9 | 30.6 |
| õºäºº | 33.1 | 32.6 | 43.4 | 37.0 | 46.6 | 49.7 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Бид өмнө Зураг -2 ба 3 –д Монгол Улсын нэг хүн амд ногдох ДНБ болон ҮНО 1990 оноос огцом буурсаныг харуулсан. Энэ нь шилжилтийн эхний жилүүдэд хуучин ЗХУ- аас үзүүлж байсан санхүүгийн дэмжлэг, тусламж зогсож, эдийн засаг хүндээр хямарч, төсвийн хөрөнгийн хомсдлоос тэр үед зонхилж байсан улсын олон зуун үйлдвэрүүд ажиллахгүй хаалгаа барьж, удалгүй эдгээр үйлдвэрүүд хувьчлагдсанаар олон мянган ажилчид ажилгүй болж, өнөөгийн ядуурлын үүд хаалга нээгдсэн билээ. Үүний дээр 1992-1993 онд манай эдийн засагт тохиосон ( ард 36-р хуудасанд Зураг-15 - ыг үз.) гипер инфляци хүн амын бодит орлого буурахад ташуур өгсөн байдаг.

Манай оронд ядуурлын анхны албан ёсны судалгаа эхэлсэн 1995 оноос хойшхи хугацаанд ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь 35- 38- ын хооронд, ядуурал дорвитой буураагүй байсаар ирлээ. Харин Зураг -14 – өөс 2003 оноос хойш хөдөөгийн хүн амын дунд ядуурал улам газар авч, хөдөөд амьдарч байгаа 2 хүн тутмын нэг нь ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай болсон нь харагдаж байна.

Зураг -14. **Хүн амын ядуурлын түвшин, хот, хөдөөгөөр, хувиар**



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

**Хүснэгт-8. Ядуу хүн амын тоо, мянга**

| | 1995 | 1998 | 2002-2003 | 2006 | 2007-2008 | 2009 | 2009/1995,% |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт хүн амын тоо | 2248,8 | 2349,1 | 2475,4 | 2594,8 | 2635,2 | 2735,8 | 121.7 |
| Ядуу хүн амын тоо | 816,3 | 836,3 | 893,6 | 835,5 | 930,0 | 1058,8 | 129.7 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл болон судлаачийн тооцоо

Хүснэгт-8 –аас харахад 1995-2009 оны хооронд ядуу хүмүүсийн тоо нийт хүн амын тооноос хурдан нэмэгдсэн байна. 2009 оны судалгааны дүнгээр манай оронд нэг сая хүн ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байгаа ажээ.

Ядуурлын талаар илүү нарийн судлахад хэрэглэглэгддэг ядуурлын гүнгийрэлт, ядуурлын мэдрэмж зэрэг үзүүлэлтүүдийг дараахь хүснэгтэд харуулав.

**Хүснэгт-9. Хүн амын ядуурлын гүнзгийрэлт, хувиар**

| | ßäóóðëûí ã¿íçãèéðýëò | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1995 | 1998 | 2002-2003 | 2006 | 2007-2008 | 2009 |
| Óëñûí ä¿í | 10.9 | 11.7 | 11.1 | 10.1 | 10.1 | 10.6 |
| õîò | 12.2 | 13.9 | 9.2 | 8.6 | 7.7 | 7.9 |
| õºäºº | 8.9 | 13 | 13.2 | 11.9 | 13.4 | 14.4 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Хүн амын хэрэглээний дундаж түвшин улсын дүнгээр ядуурлын шугамаас 10 хувиар доогуур байгааг харуулсан энэхүү үзүүлэлт үндсэндээ нэг түвшинд өөрчлөгдөөгүй бол хотод ихээхэн буурч, хөдөөд нэлээд нэмэгджээ. Эндээс хотын өрхийн хэрэглээний хэмжээ ядуурлын шугамд ойртож байхад хөдөөгийнх харин улам холдож байгаа нь ядуурал хөдөөд газар авч, өмнө нь дундаж орлоготой байсан өрхүүд ядуурч эхэлсэнтэй холбоотой гэж үзэж байна..

Харин ядуучуудын хэрэглээний тархалттай холбоотой ядуурлын мэдрэмж гэдэг үзүүлэлт бага боловч буурч, ялангуяа хотод 1995 оныхоос бараг 2 дахин буурч, харин хөдөөд нэлээд нэмэгдсэн байна.

**Хүснэгт-10. Хүн амын ядуурлын ялгаа буюу мэдрэмж, хувиар**

| | ßäóóðëûí мэдрэмж | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1995 | 1998 | 2002-2003 | 2006 | 2007-2008 | 2009 |
| Óëñûí ä¿í | 4.8 | 5.6 | 4.7 | 4.5 | 4.0 | 4.1 |
| õîò | 5.7 | 7.1 | 4.0 | 3.8 | 3.1 | 2.9 |
| õºäºº | 3.6 | 7.4 | 5.6 | 5.3 | 5.2 | 5.7 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Энэ нь хөдөөд хүний хэрэглээ ядуурлын шугамаас доош холдож байгааг харуулж байна.

## 9. Амьжиргааны түвшинд нөлөөлсөн инфляцийн нөлөөлөл

Монгол Улсын эдийн засаг шилжилтийн эхний жилүүдэд амссан том цохилтын нэг нь инфляцийн огцом өсөлт байлаа. Үүнийг Зураг -15 -аас харж болно. Үүний шалтгааныг Keith Griffin ( 3/ хуудас 21) Монголын эдийн засаг макро эдийн засгийн тогтворжилтоо хангаагүй байхдаа үнийг яаравчлан чөлөөлсөнтэй холбон тайлбарлажээ.

Шилжилтийн эхний жилүүдэд олон жил төрөөс бодлогоор барьж байсан үнийг чөлөөснөөр манай оронд гипер инфляцийн үзэгдэл явагдаж, зөвхөн 1992 онд өргөн хэрэглээний бараа,үйлчилгээний дундаж үнэ өмнөх оныхоосоо 4.2 дахин өссөн байдаг.

**Зураг-15. Инфляцийн жил бүрийн цэвэр өсөлтийн хувь**




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Монгол Улсын өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг хүн амын амьжиргааны гол үзүүлэлт болгон сонгон авлаа. Амьжиргааны түвшинд нөлөөлсөн инфляцийн нөлөөг харуулахын тулд өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг оны болон зэрэгцүүлэх үнээр тооцож дараахь хүснэгтэд харуулав.

**Хүснэгт-11. Өрхийн дундаж мөнгөн орлого, төгрөг**

| | Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого | | Инфляцийн жил бүрийн өсөлт, дахинаар | Инфляцийн суурь онтой харьцуулсан өсөлт, 1990=1 |
|---|---|---|---|---|
| | Оны үнээр | 1990 оны зэрэгцүүлэх үнээр | | |
| 1990 | 965 | 965 | 1 | 1 |
| 1991 | 949 | 621.4 | 1.52 | 1.52 |
| 1992 | 2953 | 457.1 | 4.25 | 6.46 |
| 1993 | 8187 | 692.5 | 1.83 | 11.822 |
| 1994 | 20235 | 1029.2 | 1.663 | 19.66 |
| 1995 | 33025 | 1097.2 | 1.531 | 30.1 |
| 1996 | 45916 | 1055.1 | 1.446 | 43.52 |
| 1997 | 56218 | 1071.8 | 1.205 | 52.45 |
| 1998 | 66492 | 1196.1 | 1.06 | 55.59 |
| 1999 | 68563 | 1121.2 | 1.1 | 61.15 |
| 2000 | 82859 | 1253.5 | 1.081 | 66.1 |
| 2001 | 102113 | 1430.4 | 1.08 | 71.39 |
| 2002 | 124930 | 1722.2 | 1.016 | 72.54 |
| 2003 | 144354 | 1900.9 | 1.047 | 75.94 |
| 2004 | 144127 | 1709.7 | 1.11 | 84.3 |
| 2005 | 150208 | 1627.2 | 1.095 | 92.31 |
| 2006 | 173477 | 1770.2 | 1.062 | 98 |
| 2007 | 239179 | 2071.2 | 1.178 | 115.48 |
| 2008 | 325270 | 2306.9 | 1.221 | 141.0 |
| 2009 | 354967 | 2416.1 | 1.042 | 146.92 |
| 1990-2009 оны орлогын зөрүү | 354002 | 1451 | - | - |
| 2009/1990 дахинаар | 367.84 | 2.5 | - | 146.92 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл

Судлаач өрхийн дундаж орлогыг 1990 оны зэрэгцүүлэх үнээр тооцов.

Хүснэгтэнд хийсэн тооцооноос харахад 1990 оны нэг төгрөг 2009 оны 147 төгрөгтэй тэнцэх хэмжээнд хүрч, төгрөгийн ханш өнгөрсөн 19 жилд эрс унажээ. Иймээс өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг инфляциййн өсөлтөөс цэвэрлэн түүний хэмжээг 1990 оны үнээр тооцвол 2416,1 төгрөг болж, 1990-2009 оны хооронд харин орлогын бодит өсөлт нь 250 хувь буюу 2,5 дахин нэмэгджээ. Гэтэл оны үнээрээ бол дээрх хугацаанд өрхийн мөнгөн орлого 367,8 дахин өссөн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод үзүүлсэн инфляцийн нөлөөг индексийн аргаар илүү тодорхой харуулж болно. 1990-2009 оны хоорондох өрхийн сарын дундаж мөнгөн орлогын тухайн оны үнээрх өсөлтийг дараах индексээр илэрхийлж болно.

$$I_{pq}=\frac{p_{2009}q_{2009}}{p_{1990}q_{1990}}=\frac{354967}{965}=367.84$$

Энд: р- ү

Энэ өрхийн мөнгөн орлогын өсөлтийн ерөнхий индексийг Паашийг үнийн болон биет хэмжээний индексийн үржвэрээр илэрхийлдэг.

$$I_{pq}=\frac{p_{2009}q_{2009}}{p_{1990}q_{1990}}=\frac{p_{2009}q_{2009}}{p_{1990}q_{2009}}x\frac{p_{1990}q_{2009}}{p_{1990}q_{1990}}$$

Энд манай Хүснэгт-9 -ийн тооцоогоор $p_{1990}q_{2009}=2416$ тул

$$I_{pq}=\frac{354967}{965}=\frac{354967}{2416}x\frac{2416}{965}=367.8=146.9x2.5$$ болно.

Эндээс өрхийн мөнгөн орлого 1990-2009 оны хооронд оны үнээрээ 367,8 дахин өссөний 146,9 дахин өссөн өсөлт нь цэвэр үнийн өсөлтөөс харин 2,5 дахин өссөн өсөлт нь орлогын бодит өсөлтөөс гарсан байна. Үүнийг абсалют хэмжээгээр илэрхийлбэл өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 1990-2009 оны хооронд өссөн абсалют цэвэр өсөлт оны үнээрэ:

$\Delta pq=p_{2009}q_{2009}-p_{1990}q_{1990}=354002$ төгрөг болно.

Зөвхөн үнийн өсөлтөөс нэмэгдсэн өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ:

$\Delta p=p_{2009}q_{2009}-p_{1990}q_{2009}=354967-2416=352551$ төгрөг гарлаа.

Харин өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бодит өсөлтийн хэмжээ:

$$\Delta q = p_{1990} q_{2009} - p_{1990} q_{1990} = 2416 - 965 = 1451$$ төгрөг гарч байна.

Эндээс 1990-2009 оны өрхийн сарын дундаж мөнгөн орлогын цэвэр өсөлтийн ( 354002 төгрөг) 99,6 хувь буюу 352551 төгрөг нь цэвэр үнийн буюу инфляцийн өсөлтөөс үүдэлтэй, харин дөнгөж 0.4 хувь буюу 1990 оны үнээр 1451 төгрөг нь орлогын бодит өсөлтөөс бий болжээ.

Эндээс харахад Монгол Улсын хүн амын орлого, амьжиргааны түвшинд инфляци маш хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн нь тодорхой байна.

Одоо инфляци ядуурлын шугамд хэрхэн нөлөөлснийг авч үзье. Ядуурлын түвшинг тооцохдоо амьжиргааны доод түвшинг ядуурлын шугам болгон авч түүнээс доогуур хэрэглээтэй хүн амын нийт хүн амд эзлэх хувиар гаргадаг. Тэгэхлээр манай орны хувьд ядуурлын түвшинг тодорхойлоход ядуурлын шугам маш чухал үүрэгтэй байдаг. Тэгвэл ядуурлын шугамын өсөлтөнд инфляци хэрхэн нөлөөлснийг судлаж үзье.

**Хүснэгт-12. Ядуурлын шугам ба инфляцын түвшин**

| | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Амьжиргааны доод түвшин, Улаанбаатарт, мянган төгрөг | 19.3 | 23.6 | 24.6 | 25.3 | 26.5 | 30 | 42.8 | 60.1 | 94.8 | 101.1 |
| Инфляцийн жил бүрийн цэвэр өсөлт, % | 8,1 | 8.0 | 1.6 | 4.7 | 11.0 | 9.5 | 6.2 | 17.8 | 22.1 | 4.2 |
| Ядуурлын шугамын өсөлт, 2000=1 | 1.0 | 1.22 | 1.27 | 1.31 | 1.37 | 1.55 | 2.22 | 3.11 | 4.91 | 5.24 |
| Инфляцийн суурь онтой харьцуулсан өсөлт, 2000=1 | 1.0 | 1.08 | 1.097 | 1.1488 | 1.275 | 1.396 | 1.48 | 1.747 | 2.133 | 2.222 |

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2003, 2005, 2009 он.

Хүснэгтээс харахад 2000-2009 оны хооронд 9 жилд инфляци 2,2 дахин нэмэгдсэн байхад ядуурлын шугам 5,2 дахин өсчээ. Энэ байдал дээрх хүснэгтийн өгөгдлөөр байгуулсан дараахь зургаас бүр ч тодорхой харагдана.

**Зураг-16. Хэрэглээний үнэ болон ядуурлын шугамын өсөлт, 2000=1**




Эндээс ядуурлын шугамыг ялангуяа 2005 оноос хойш тодорхойлж, зарлахдаа инфляцийн өсөлттэй уялдуулаагүй хэт өндрөөр тогтоосон байна. Энэ нь манай оронд ядуурал буурахгүй байгаа гол шалтгаан болжээ. Ядуурлын шугам бодит байдлаас өндөр, улам бүр өссөөр ирсэн тул ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрх улам нэмэгдэх нь аргагүй юм. Хүснэгтээс харахад 2000 оны ядуурлын шугамыг суурь болгосон Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшинг хэрэглээний үнийн өсөлтөөр засварлан тооцвол 2007 онд 33.7 мянган төгрөг, 2008 онд 2.3 дахин бага буюу 41.2 мянган төгрөгөөс хэтрэхээргүй байжээ. Ийм учрас 2007-2008 онд явагдсан өрхийн нийгэм –эдийн засгийн судалгааны дүнгээс ядуурлын шугамыг дээрх хэмжээгээр засварлан авч, ядуурлын түвшинг улсын хэмжээнд болон бүс нутгаар дахин тооцох шаардлага гарч байна. Хэрвээ ийм байдлаар тооцоог зөв хийвэл 2007-2008 оны судалгааны дүнгээр Монгол Улсад ядуурал буурсан дүн гарахаар байна. Эндээс инфляци ядуурлын шугамд нөлөөлөөгүй, харин эсрэгээрээ түүнийг инфляцийн өсөлттэй уялдуулаагүй, түүнээс хэт өндрөөр тогтоож иржээ.

## 10. Амьжиргааны түвшин, ядуууралд нөлөөлсөн ажилгүйдэл, орлогын нөлөөлөл

Бид дээр ядуурлын чиг хандлагыг авч үзэж, ядуурал манай оронд төдийлөн буурахгүй байгааг тэмдэглэсэн. Хүн ам, оррн сууцны 2000 оны тооллого болон ажил эрхлэлтийн судалгааны дүнгээр ажилгүйдлийн түвшин ч мөн дорвитой буураагүй дүн гарсаныг доор

хүснэгтэд харуулав. Ажилгүйдэл, ядуурлын манай орны хувьд олон жил үргэлжилсэн, эдийн засаг,нийгмийн хөгжлийн нэн тулгамдсан шийдвэрлэх асуудал хэвээр байна.

**Хүснэгт -13. Ядуурал, ажилгүйдлийн үзүүлэлтүүд**

| | 2000 | 2003 | 2007-2008 | 2009 |
|---|---|---|---|---|
| Ядуурлын хамралт,% | 35,6* | 36.1 | 35.2 | 38.7 |
| Ажилгүйдлийн түвшин,% | 17,7 | 14,1 | 11,3 | 11,5 |
| Ядуучуудын тоо, мянга | 836.3 | 893.6 | 928,5 | 1058.8 |
| Ажилгүйчүүдийн тоо,мянга | 164,9 | 142,3 | 119,1 | 130,5 |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны тоо мэдээлэл, ядуучууд, ажилгүй хүмүүсийн зарим оны тоог судлаач тооцож гаргав.

*1998

2005 оны 9 дүгээр сард болсон Дэлхийн дээд хэмжээний уулзалтыг үеэр улс орнуудын тэргүүнүүд ядуурлыг бууруулах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн чухлыг хүлээн зөвшөөрч, “ Хүн бүрийг түүний дотор залуучууд эмэгтэйчүүдийг бүтээмж өндөртэй ажлын байраар бүрэн хангах” тухай шинэ зорилтыг санал нэгтэй дэмжсэн билээ. Энд ажилгүйдэл нь ядуурлын гол шалтгаан болдогыг дэлхий даяар хүлээн зөвшөөрсөн байна.

Ядуурал нь ажилгүйдэлтэй шууд холбоотой болох нь манай оронд 2002-2003 онд болон 2007-2008 онд явагдсан амьжиргааны түвшний судалгааны дүнгээр нотлогдож байна.

**Хүснэгт -14. Ажилгүйдлийн түвшин, ядуу ба ядуу бус хүн амаар,%**

| | 2002-2003 он | | | 2007-2008 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нийт | Ядуу | Ядуубус | Нийт | Ядуу | Ядуубус |
| Улсын дундаж | 6,6 | 10,2 | 4,9 | 8,2 | 12,3 | 6,2 |
| - хот | 9,1 | 15,9 | 6,8 | 10,4 | 18,7 | 7,7 |
| - хөдөө | 4,1 | 6,5 | 2,6 | 5,7 | 8,2 | 3,7 |

Эх сурвалж: 1.Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2002-2003 оны түүвэр судалгааны үндсэн тайлан, 2004
2. Монгол дахь ядуурлын дүр төрх, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгааны дүн, 2009 он

Хүснэгт -14 – өөс харахад  ядуу хүмүүсийн дунд ажилгүйдэл  илүү түгээмэл байна. 2002-2003 оны судалгаагаар  ядуу бус хүмүүсийн дунд ажилгүйдэл харьцангуй бага 4,9 хувьтай байсан бол   ядуу хүмүүсийн дунд 10,2 хувь буюу 2 дахин өндөр байв. Энэ байдал 2007-2008 оны судалгаагаар ч мөн давтагдсан байна. Сүүлийн  судалгаагаар  ядуучуудын дунд ажилгүйдэл 12,3 хувь байгаа нь   ядуу бус хүмүүсийнхээс  (6.2%)  мөн л 2 дахин өндөр гарчээ. 2007-2008 оны судалгааны дүнг өмнөх 2002-2003 оны судалгаатай харьцуулахад  ядуу хүмүүсийн дунд ажилүйдлийн түвшин 10,2 оос 12,3  болж улам нэмэгдсэн, ялангуяа  энэ байдал хот, суурин газарт  илүүтэй өсөж бүр 18,7 хувьд хүрсэн байна.    Ядуурालд ажилгүйдэл ихээхэн нөлөөлж байгаа нь  дараах хүснэгтээс бас харагдаж байна.

Ядуурлын хамралтын түвшин  2002-2003 оны судалгаагаар  улсын дунджаар 36,1 хувь, өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхүүдийн хувьд 33,6 хувь байсан бол өрхийн тэргүүлэгч нь ажилгүй  өрхийн хувьд бүр өндөр 48,7 хувь байжээ.

**Хүснэгт-15. Ядуурлын үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар**

| | 2002-2003 он | | | 2007-2008 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нийт | ажилтай | ажилгүй | нийт | ажилтай | ажилгүй |
| Ядуурлын хамралтын хүрээ | 36,1 | 33,6 | 48,7 | 35,2 | 34,3 | 54,4 |
| Ядуурлын гүнзгийрэлт | 11,0 | 9,7 | 16,7 | 10,1 | 9,4 | 19,6 |
| Ядуурлын мэдрэмж | 4,7 | 3,9 | 7,4 | 4,0 | 3,6 | 9,1 |

Эх сурвалж: 1.Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний  2002-2003 оны түүвэр судалгааны үндсэн тайлан, 2004
2. Монгол дахь ядуурлын дүр төрх, Өрхийн нийгэм, эдийн засгийн  2007-2008 оны судалгааны дүн, 2009 он

Энэ байдал 2007-2008 оны судалгаагаар л мөн давтагдаж, харин  ядуурал  газар  авч, өрхийн тэргүүлэгч  нь ажил эрхэлдэггүй өрхүүдийн дунд ядуурлын хамрагдалт 54,4 хувьд хүрчээ. Энэ нь  хүн амын  ажилгүйдэл нь ядуурлын нэг гол шалтгаан гэдгийг  дахин нотлож байна.

Зураг -17 –оос  манай орны  нэг өрхийн дундаж мөнгөн орлого, нийт зарлага хоёр харилцан хамааралтай  өсөж ирснийг  харж болно.

**Зураг-17. Нэг өрхийн сарын дундаж зарлага болон мөнгөн орлого, оны үнээр, төгрөг**




Нийт зарлага нь мөнгөн зарлагаас гадна мөнгөн бус хэлбэрийн зарцуулалтыг оруулсан, мөн өрхүүд орлогоосоо давсан зарлагыг зээл, бусдаас авсан тусламжаар хааж байгаа тул зарлага нь орлогоосоо өндөр байдаг. Энэ нөхцөлд амьжиргааны түвшний судалгааны хэрэглээний зардлыг орлогыг төлөөлүүлэн авч судалгаанд ашиглаж болно.

**Хүснэгт-16. Сард нэг хүнд ногдох хэрэглээ, ядуу болон ядуу бус өрхөөр, төгрөг**

| | 2002-2003 он | | 2007-2008 он | |
|---|---|---|---|---|
| | Ядуу өрхүүд | Ядуу бус өрхүүд | Ядуу өрхүүд | Ядуу бус өрхүүд |
| Нийт хэрэглээ | 17214 | 47790 | 44589 | 131483 |
| Хүнсний хэрэглээ | 9002 | 20504 | 23188 | 43340 |

Эх сурвалж: 1.Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2002-2003 оны түүвэр судалгааны үндсэн тайлан, 2004

2. Монгол дахь ядуурлын дүр төрх, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгааны дүн, 2009 он

Дээрх хүснэгтээс харахад 2002-2003 оны судалгаагаар ядуу өрхүүдийн сарын дундаж нийт хэрэглээ ядуу бус өрхүүдийнхээс 2,8 дахин доогуур байсан бол 2007-2008 оны судалгаагар 2,9 дахин доогуур гарчээ. Ядуу өрхүүдийн сарын дундаж хүнсний хэрэглээний зардал 2002-2003 оны судалгаагаар ядуу бус өрхүүдийнхээс 2,3 дахин доогуур, 2007-2008 оны судалгаагаар 1,9 дахин доогуур гарчээ. Энэ нь ядуу өрхүүдийн хэрэглээ ядуу бус

өрхүүдийнхээс  ихээхэн доогуур, энэ утгаараа ядуу өрхүүдийн орлого мөн их доогуур гэсэн үг юм.  Ийнхүү өрхийн орлого, хэрэглээний түвшин амьжиргааны түвшинтэй шууд холбоотой нь харагдаж байна.

**11. Хүний хөгжил, эдийн засгийн өсөлт  ба  амьжиргааны түвшин**

Хүний  хөгжлийн үзэл баримтлал  ихээхэн өргөн хүрээтэй бөгөөд  хүний сонголт хийх болон  эрх чөлөөгөө эдлэх боломжийг өргөжүүлэхтэй голлон холбон авч үздэг. 1990 оноос НҮБ –ын хөгжлийн Хөтөлбөрийн газраас  дэлхийн хүний хөгжлийн илтгэлийг хэвлэн гаргадаг болсон. Сүүлчийнх  2007-2008  оны дэлхийн хүний хөгжлийн илтгэл бөгөөд ( UNDP,16)  түүнийг дэлхийн цаг уурын өөрчлөлт ба хүний хөгжил гэсэн ерөнхий  сэдвийн хүрээнд бэлгэжээ. Манай орон  1997 онд анхны хүний хөгжлийн анхны илтгэлээ хэвлэн гаргасан. Дараагийн илтгэлүүд 2000,2003,2007 онуудад гаргаж байжээ.




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны  тоо мэдээлэл

1998-1995 оны мэдээллийн эх сурвалж: ADB, Mongolia Country Poverty Assessment (CPA).2009

Зураг-18  -аас харахад  манай оронд хүний хөгжлийн индекс 1990 –ээд оны дунд үеэс эхлэн тогтвортой өссөөр иржээ. Гэвч   дэлхийн хүний хөгжлийн 2007-2008 оны илтгэлд Монгол Улс  2005 оны мэдээллээр дэлхийн 177 орноос 114 дүгээр байранд оржээ.

Монгол Улс олон улсын хэмжээнд ХХИ – ээр нэлээн хойгуур байр эзэлж байгаа нь уг индексийн тооцоонд ордог нэг хүн амд ногдох худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон ДНБ- ний хэмжээ дэлхийн бусад оронтой харьцуулахад доогуур байгаатай холбоотой. Нөгөө талаараа энэ үзүүлэлт эдийн засгийн өсөлтийг илэрхийлдэгийг бид дээр дурьдсан. Дэлхийн банкнаас гаргадаг “Дэлхийн Хөгжлийн үзүүлэлтүүд-2007” эмхтгэлд Монгол Улс худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон нэг хүн амд ногдох үндэсний нийт орлогоороо дэлхийн 2008 орноос 161 дүгээр байранд орсон нь манай ХХИ буурч гарахад нөлөөлжээ.

Зураг -19- д үзүүлсэн харьцуулалтаар Монгол Улс бага орлоготой ядуу орнуудын ангилалд багтаж байгаа юм. Эндээс Монгол хүний амьжиргааны түвшин дэлхийн хэмжээнд зэрэгцүүлбэл хаана яваа нь тодорхой харагдаж байна. Нөгөө талаараа улс орнууд эдийн засгийнхаа өсөлтийг ихэвчлэн нэг хүн амд ногдох ДНБ болон ҮНҮ –оор хэмждэг.

**Зураг-19. Худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон нэг хүн амд ногдох үндэсний нийт орлого, 2005 оноор, ам. доллароор**




Эх сурвалж: World bank, World Development Indicators, 2007

Хүний хөгжлийн үзүүлэлт амьжиргааны түвшин, эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүд өөр хоорондоо ихээхэн хамааралтай нь эндээс харагдана. Хүний хөгжлийн нэг гол үзүүлэлт нь хүмүүсийн боловсролын түвшин байдаг.

**Хүснэгт- 17. Боловсрол ба ядуурлын хамаарал**

| | 2002-2003 он | | 2007-2008 он | |
|---|---|---|---|---|
| | Ядуу өрхүүд | Ядуу бус өрхүүд | Ядуу өрхүүд | Ядуу бус өрхүүд |
| Боловсролгүй | 39,4 | 60,6 | 54,6 | 45,4 |
| Бага боловсролтой | 38,4 | 61,6 | 45,9 | 54,1 |
| Бүрэн бус дунд | 42,7 | 57,3 | 47,1 | 52,9 |
| Бүрэн дунд | 29,5 | 70,5 | 30,1 | 69,9 |
| МАШ | 34,4 | 65,6 | 22,0 | 78,0 |
| Дипломын дээд | 19,2 | 80,9 | 9,3 | 90,7 |
| Дээд | 8,2 | 91,6 | 9,7 | 91,3 |

Эх сурвалж: 1.Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2002-2003 оны түүвэр судалгааны үндсэн тайлан, 2004

2. Монгол дахь ядуурлын дүр төрх, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгааны дүн, 2009 он

Хүснэгт-17 нь боловсролын түвшин болон ядуурлын хооронд тодорхой хамаарал байгааг хуруулж байна. 2002-2003 оны өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгааны дүнгээр ядуу өрхүүдийн насанд хүрсэн хүн амын дотор дээд боловсролтой хүн дөнгөж 8,2 хувь эзэлж байхад ядуу бус өрхүүдийн хувьд энэ үзүүлэлт 91,6 хувь байна. Энэ нь хүний хөгжил,түүний дотор боловсролын түвшин өндөр байх нь ядуурлаас хол байх нөхцөл гэдгийг харуулж байна. Энэ байдал 2007-2008 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр ч мөн ийм гарчээ. Ядуу өрхүүдийн дотор өндөр боловсролтой хүмүүсийн эзлэх хувь бага байхад ядуу бус өрхүүдийн дотор эсрэгээр өндөр боловсролтой хүмүүсийн эзлэх хувь харьцангуй их байгаа өрөнхий зүй тогтол ажиглагдаж байна.

**Хүснэгт- 18. Ядуурлын хамралтын хүрээ, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр, %**

| | 2002-2003 он | | | 2007-2008 он | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Улсын дүн | хот | хөдөө | Улсын дүн | хот | хөдөө |
| Боловсролгүй | 45,8 | 52,3 | 43,8 | 58,0 | 57,7 | 58,2 |
| Бага боловсролтой | 45,6 | 48,1 | 44,5 | 51,5 | 47,3 | 52,7 |
| Бүрэн бус дунд | 45,5 | 47,7 | 43,8 | 48,1 | 45,3 | 50,0 |
| Бүрэн дунд | 34,9 | 29,2 | 44,8 | 34,6 | 29,9 | 44,7 |
| МАШ | 40,7 | 34,9 | 50,2 | 25,3 | 21,1 | 34,9 |
| Дипломын дээд | 23,4 | 19,6 | 34,4 | 9,5 | 8,3 | 16,1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Дээд | 11,6 | 8,8 | 29,0 | 8,8 | 7,9 | 15,6 |

Эх сурвалж: 1.Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2002-2003 оны түүвэр судалгааны үндсэн тайлан, 2004

2. Монгол дахь ядуурлын дүр төрх, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгааны дүн, 2009 он

Хүснэгт-18 –д өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин өндөр байх тусам уг өрхийн ядуурлад өртөх байдал буурч байна. 2002- 2003 оны судалгааны дүнгээр улсын дүнгээр дээд боловсролтой өрхийн тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурлын түвшин 11,6 хувьтай байсан нь улсын хэмжээний ядуурлын түвшнээс ( 36.1% ) 3 дахин доогуур байжээ. Гэтэл өрхийн тэргүүлэгч нь огт боловсролгүй өрхүүдийн ядуурлын хамралт 45,8 хувь байгаа нь улсын дунджаас ихээхэн өндөр байна. 2007-2008 оны судалгааны дүнгээр дээд боловсролтой болон огт боловсролүй өрхийн тэргүүлэгчтэй өрахүүдийн ядуурлын ялгаа нь нэмэгдэж гарчээ. Эндээс хүний хөгжил нь өрхийн амьжиргааны түвшинд ихээхэн нөлөөтэй болох нь батлагдаж байна.

**12. Олон улсын зэрэгцүүлэлт**

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 1990 оноос эхлэн жил бүр “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-ийг эрхлэн гаргаж байгаа нь манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зарим үндсэн үзүүлэлтийг бүс нутаг, дэлхийн дундаж үзүүлэлттэй харьцуулан үзэх боломжийг олгож байна. Хүний хөгжлийн илтгэлийн үндсэн үзүүлэлтийн нэг болох хүний хөгжлийн индексийг тооцохдоо 2009 он хүртэл улс орны хөгжлийг үндэсний нийт орлогоос гадна дундаж наслалт, бичиг үсэг тайлагдалтын түвшин зэргээр илэрхийлдэг байсан.

Харин “Хүний хөгжлийн 2010 оны илтгэл”-д хүний хөгжлийн индексийг дундаж наслалт, сургуульд хамрагдсан дундаж хугацаа, сургуульд хамрагдах хүлээгдэж буй хугацаа, нэг хүнд ногдох ҮНО гэсэн хэмжигдэхүүнээр тооцжээ.

Дэлхийн “Хүний хөгжлийн илтгэл 2010”-д үзүүлснээр нь Монгол хүний хөгжлийн индекс 2010 онд 0.622 оноогоор 169 орноос 100-р байр эзэлсэн нь Зүүн Ази, Номхон далайн хөгжиж буй орнуудын дунджаас 0.021 пунктээр, дэлхийн дунджаас 0.002 пунктээр доогуур байна.

**Хүснэгт-19. Хүний хөгжлийн индекс, түүний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд, бүс нутаг болон бусад ангилалаар**

| | Хүний хөгжлийн индекс, 2010 | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хүний хөгжлийн индекс (ХХИ) | Дундаж наслалт | Сургуульд хамрагдсан дундаж хугацаа | Сургуульд хамрагдах хүлээгдэж буй хугацаа | Нэг хүнд ногдох ҮНО (2008 ХАЧП, ам.дол) | Орлогын бус ХХИ |
| Монгол | 0.622 | 67.3 | 8.3 | 13.5 | 3619 | 0.710 |
| ***Хөгжингүй орнууд*** | | | | | | |
| ЭЗХАХБ-ын орнууд | 0.879 | 80.3 | 11.4 | 15.9 | 37077 | 0.904 |
| ЭЗХАХБ-ын орнуудаас бусад | 0.844 | 80.0 | 10.0 | 13.9 | 42370 | 0.845 |
| ***Хөгжиж буй орнууд*** | | | | | | |
| Арабын улсууд | 0.588 | 69.1 | 5.7 | 10.8 | 7861 | 0.610 |
| Зүүн Ази, Номхон далайн орнууд | 0.643 | 72.6 | 7.2 | 11.5 | 6403 | 0.692 |
| Европ болон Төв Азийн орнууд | 0.702 | 69.5 | 9.2 | 13.6 | 11462 | 0.740 |
| Латин Америк, Карибын тэнгисийн орнууд | 0.704 | 74.0 | 7.9 | 13.7 | 10642 | 0.746 |
| Өмнөд Ази | 0.516 | 65.1 | 4.6 | 10.0 | 3417 | 0.551 |
| Сахар орчмын Африкийн орнууд | 0.389 | 52.7 | 4.5 | 9.0 | 2050 | 0.436 |
| **Хүний хөгжлийн ангилал** | | | | | | |
| Хүний хөгжил маш өндөр орнууд | 0.878 | 80.3 | 11.3 | 15.9 | 37225 | 0.902 |
| Хүний хөгжил өндөр орнууд | 0.717 | 72.6 | 8.3 | 13.8 | 12286 | 0.749 |
| Хүний хөгжил дундаж орнууд | 0.592 | 69.3 | 6.3 | 11.0 | 5134 | 0.634 |
| Хүний хөгжил бага орнууд | 0.393 | 56.0 | 4.1 | 8.2 | 1490 | 0.445 |
| Нэн буурай хөгжилтэй орнууд | 0.386 | 57.7 | 3.7 | 8.0 | 1393 | 0.441 |
| Дэлхийн дундаж | 0.624 | 69.3 | 7.4 | 12.3 | 10631 | 0.663 |

Эх үүсвэр: НҮБХХ , Хүний хөгжлийн илтгэл – 2010

Улс орнуудыг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээгээр нь байр эзлүүлэхэд манай улс ХХИ-ээр 2010 онд эзэлсэн байраасаа 12-оор ухарчээ. Харин нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын үзүүлэлтийг оруулаагүй тооцсон ХХИ 0.710 байгаа нь Зүүн Ази, Номхон далайн орнууд болон дэлхийн дунджаас 0.018-0.047 пунктээр дээгүүр байна. Энэ нь манай улсын хувьд орлогын үзүүлэлт бусад үзүүлэлтээсээ доогуур түвшинд байгааг харуулж байна.

Манай улсад хүн амын дундаж наслалт 2010 онд 67.3 байгаа нь Зүүн Ази, Номхон далайн орнуудын түвшнээс 5.3 жилээр, дэлхийн дунджаас 2.0 жилээр бага байна.

Харин сургуульд хамрагдсан дундаж хугацаа болон сургуульд хамрагдах хүлээгдэж буй хугацаа нь нь хөгжиж буй ихэнх бүс нутгаас өндөр байна.

Гэвч нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ валютын худалдан авах чадварын паритетаар 2010 онд 3619 ам.доллар байгаа нь Зүүн Ази, Номхон далайн орнуудын дунджаас 2784 ам.доллар буюу 76.9 хувь, дэлхийн дунджаас 7012 ам.доллараар буюу 2.9 дахин бага байна.

**Зураг-20. Монголын хүний хөгжлийн орлогын индекс, 1990-2010 он**




Эх үүсвэр: НҮБХХ , Хүний хөгжлийн илтгэл – 2010

Монгол хүний хөгжлийн индекс 2010 онд 0.622 болж 1990 оныхоос 0.102 пунктээр, 2000 оныхоос 0.083 пунктээр тус тус өссөн байна. Хүний хөгжлийн индекс 1990-2010 онд жилд дунджаар 0.9 хувиар, 2000-2010 онд жилд дунджаар 1.43 хувиар өсчээ.

Хөгжиж буй орнуудаас 2010 онд Латин Америк, Карибын тэнгисийн орнуудын хүний хөгжлийн индекс хамгийн өндөр буюу 0.704 болж 1990 оныхоос 0.131 пунктээр өсчээ. Европ болон Төв Азийн хөгжиж буй орнуудын ХХИ 2010 онд 0.702 болж 1990 оныхоос 0.199 пунктээр, Зүүн Ази, Номхон далайн орных 0.643 болж 0.26 пунтээр, Арабын улсуудынх 0.588 болж 0.192 пунктээр, Өмнөд Азийнх 0.516 болж 0.201 пунктээр, Сахар орчмын Африкийн орнуудынх 0.389 болж 0.096 пунктээр өсчээ.

**Хүснэгт- 20. Хүний хөгжлийн индекс, бүс нутаг болон бусад ангилалаар 1980-2010 он**

| | Хүний хөгжлийн индекс (ХХИ) Оноо | | | | | | | ХХИ-ийн жилийн дундаж өсөлт, хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1980 | 1990 | 1995 | 2000 | 2005 | 2009 | 2010 | 1980-2010 | 1990-2010 | 2000-2010 |
| Монгол | ... | 0.520 | 0.502 | 0.539 | 0.588 | 0.616 | 0.622 | … | 0.90 | 1.43 |
| ***Хөгжингүй орнууд*** | | | | | | | | | | |
| ЭЗХАХБ-ын орнууд | 0.754 | 0.798 | 0.827 | 0.852 | 0.868 | 0.876 | 0.879 | 0.51 | 0.48 | 0.31 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЭЗХАХБ-ын орнуудаас бусад | 0.701 | 0.761 | 0.779 | 0.799 | 0.829 | 0.840 | 0.844 | 0.62 | 0.51 | 0.54 |
| ***Хөгжиж буй орнууд*** | | | | | | | | | | |
| Арабын улсууд | 0.396 | 0.470 | 0.505 | 0.525 | 0.562 | 0.583 | 0.588 | 1.32 | 1.12 | 1.14 |
| Зүүн Ази, Номхон далайн орнууд | 0.383 | 0.466 | 0.519 | 0.559 | 0.600 | 0.636 | 0.643 | 1.73 | 1.61 | 1.40 |
| Европ болон Төв Азийн орнууд | 0.503 | 0.660 | 0.628 | 0.648 | 0.679 | 0.698 | 0.702 | 1.11 | 0.31 | 0.80 |
| Латин Америк, Карибын тэнгисийн орнууд | 0.573 | 0.614 | 0.640 | 0.660 | 0.681 | 0.699 | 0.704 | 0.68 | 0.68 | 0.64 |
| Өмнөд Ази | 0.315 | 0.387 | 0.415 | 0.440 | 0.481 | 0.510 | 0.516 | 1.65 | 1.44 | 1.61 |
| Сахар орчмын Африкийн орнууд | 0.293 | 0.354 | 0.358 | 0.315 | 0.366 | 0.384 | 0.389 | 0.94 | 0.46 | 2.10 |
| ***Хүний хөгжлийн ангилал*** | | | | | | | | | | |
| Хүний хөгжил маш өндөр орнууд | 0.753 | 0.797 | 0.827 | 0.851 | 0.867 | 0.875 | 0.878 | 0.51 | 0.48 | 0.31 |
| Хүний хөгжил өндөр орнууд | 0.556 | 0.633 | 0.634 | 0.659 | 0.692 | 0.712 | 0.717 | 0.85 | 0.62 | 0.84 |
| Хүний хөгжил дундаж орнууд | 0.361 | 0.440 | 0.480 | 0.510 | 0.555 | 0.586 | 0.592 | 1.65 | 1.49 | 1.49 |
| Хүний хөгжил бага орнууд | 0.271 | 0.310 | 0.324 | 0.332 | 0.366 | 0.388 | 0.393 | 1.24 | 1.19 | 1.68 |
| Нэн буурай хөгжилтэй орнууд | 0.251 | 0.292 | 0.311 | 0.325 | 0.357 | 0.382 | 0.386 | 1.44 | 1.40 | 1.72 |
| Дэлхийн дундаж | 0.455 | 0.526 | 0.554 | 0.570 | 0.598 | 0.619 | 0.624 | 1.05 | 0.85 | 0.89 |

Эх үүсвэр: НҮБХХ , Хүний хөгжлийн илтгэл – 2010

Сахар орчмын Африкийн орнуудын хүний хөгжлийн индекс 2000-2010 онд жилд дунджаар 2.1 хувиар өссөн байна.

Хүний хөгжлийн 2010 оны илтгэлд хүний хөгжлийн индексээс гадна i)*Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан, Хүний хөгжлийн индекс* (Inequality adjusted Human development index), ii) *Ядуурлын олон хэмжигдэхүүнт индекс* (Multidimensional poverty index), iii)*Жендерийн тэгш бус байдлын индекс* (Gender inequality index) гэсэн 3 үзүүлэлтийг шинээр тооцож оруулжээ.

**Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан хүний хөгжлийн индекс**

Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан ХХИ-ийг (ТХХИ) 139 орноор тооцсон бөгөөд энэ үзүүлэлт нь эрүүлд мэнд, боловсрол, орлого зэрэг хэмжигдэхүүний тэгш бус байдлын улмаас хүний хөгжлийнхөө хэдэн хувийг алдаж байна вэ гэдгийг харуулна. Улс орнуудын хувьд эдгээр 3 хэмжигдэхүүний алдагдал янз бүр, тухайлбал Чехид боловсролын үзүүлэлт 1 хувийн, Намиб улсад орлогын үзүүлэлт 68 хувийн алдагдалтай байна.

ТХХИ нь улс орны хүний хөгжлийн дундаж хэмжигдэхүүнээс гадна орлогын хуваарилалт ямар байгааг харуулна. Хэрвээ иргэн бүрийн дундаж наслалт, боловсрол, орлогын түвшин ижил гэж үзвэл ТХХИ нь ХХИ-тэй ижил гарах юм. ХХИ болон ТХХИ-ийн хоорондын зөрүү нь тэгш бус байдлаас шалтгаалсан хүний хөгжлийн боломжит алдагдлыг харуулж байна.

**Хүснэгт- 21. Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан хүний хөгжлийн индекс, бүс нутаг болон бусад ангилалаар**

| | Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан хүний хөгжлийн индекс | | Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан дундаж наслалтын индекс | | Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан боловсролын индекс | | Тэгш бус байдлын үзүүлэлтээр засварласан орлогын индекс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Оноо | Нийт алдагдал,хувь | | | | | | |
| Монгол | 0.527 | 15.2 | 0.579 | 22.6 | 0.635 | 5.8 | 0.399 | 16.4 |
| ***Хөгжингүй орнууд*** | | | | | | | | |
| ЭЗХАХБ-ын орнууд | 0.789 | 10.2 | 0.907 | 5.0 | 0.810 | 5.6 | 0.669 | 19.5 |
| ЭЗХАХБ-ын орнуудаас бусад | 0.756 | 10.5 | 0.900 | 5.3 | 0.790 | 4.3 | 0.607 | 21.8 |
| ***Хөгжиж буй орнууд*** | | | | | | | | |
| Арабын улсууд | 0.426 | 27.6 | 0.619 | 21.6 | 0.289 | 43.4 | 0.432 | 17.7 |
| Зүүн Ази, Номхон далайн орнууд | 0.505 | 21.5 | 0.699 | 16.3 | 0.452 | 21.2 | 0.407 | 27.1 |
| Европ болон Төв Азийн орнууд | 0.607 | 13.6 | 0.672 | 14.3 | 0.623 | 11.9 | 0.535 | 16.1 |
| Латин Америк, Карибын тэнгисийн орнууд | 0.527 | 25.1 | 0.728 | 15.1 | 0.510 | 22.1 | 0.395 | 37.6 |
| Өмнөд Ази | 0.361 | 30.2 | 0.499 | 30.4 | 0.246 | 41.3 | 0.383 | 14.5 |
| Сахар орчмын Африкийн орнууд | 0.261 | 32.8 | 0.294 | 43.8 | 0.254 | 34.1 | 0.238 | 26.0 |
| ***Хүний хөгжлийн ангилал*** | | | | | | | | |
| Хүний хөгжил маш өндөр орнууд | 0.789 | 10.2 | 0.907 | 5.0 | 0.810 | 5.7 | 0.668 | 19.5 |
| Хүний хөгжил өндөр орнууд | 0.575 | 19.8 | 0.718 | 13.8 | 0.561 | 17.6 | 0.472 | 28.1 |
| Хүний хөгжил дундаж орнууд | 0.449 | 24.3 | 0.611 | 22.4 | 0.369 | 29.3 | 0.401 | 21.9 |
| Хүний хөгжил бага орнууд | 0.267 | 32.0 | 0.348 | 40.8 | 0.227 | 38.2 | 0.242 | 23.2 |
| Нэн буурай хөгжилтэй орнууд | 0.263 | 31.9 | 0.375 | 39.0 | 0.209 | 38.0 | 0.232 | 22.3 |
| Дэлхийн дундаж | 0.489 | 21.7 | 0.630 | 21.3 | 0.436 | 28.2 | 0.425 | 22.7 |

Сахар орчмын Африкийн орнууд гурван хэмжигдэхүүн тус бүрийн тэгш бус байдлаас шалтгаалж хүний хөгжлийнхөө 32.8 хувийг алдсан байна. Харин Европ, Төв Азийн орнууд хамгийн бага буюу хүний хөгжлийнхээ 13.6 хувийг тэгш бус байдлын улмаас алджээ.

Манай орны хувьд ХХИ 2010 онд 0.622 байгаа боловч ТХХИ 0.527 болж, хүний хөгжил 15.2 хувиар буурсан тооцоо гарчээ. Энэ нь Монгол Улс ХХИ-ээр хүрсэн түвшингээсээ 16 байраар ухарч байгааг илтгэж байна.

**Ядуурлын олон хэмжигдэхүүнт индекс**

Ядуурлын олон хэмжигдэхүүнт индекс (ЯОХИ) нь өрхийн эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны түвшинд дутагдаж буй зайлшгүй хэрэгцээ (гачигдал)-г тодорхойлно. Ядуурлыг өнөө үед хангалттай бус орлогоос гадна эрүүл мэнд, хоол хүнсээр авч буй

илчлэгийн хэмжээ, боловсрол, орон сууц, нийгэм дэх оролцоо зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлох болсон.

Энэхүү үзүүлэлт нь НҮБХХ-өөс 1997 оноос тооцож эхэлсэн Хүний ядуурлын индексийн (ХЯИ) шинэчилсэн хувилбар юм.

Хэрвээ тухайн өрх дээрх 10 үзүүлэлтээс 2-с 6-д гачигдалтай байвал олон хэмжигдэхүүнт ядуурален өртсөн гэж үзнэ.

Хөгжиж буй 104 орны нийт хүн амын 1/3 нь буюу ойролцоогоор 1.75 тэрбум хүн ам олон хэмжигдэхүүнт ядуурална өртсөн гэсэн тооцоо гарчээ. Эдгээрийн 50 гаруй хувь нь Өмнөд Азид амьдарч байна.




Манай улсын ЯОХИ 0.065 байгаа нь олон хэмжигдэхүүнт ядуурална өртсөн хүн ам нийт хүн амын 15.8 хувийг эзэлж байгааг харуулж байна.

**Хүснэгт -22. Ядуурлын олон хэмжигдэхүүнт индекс, түүний бүрэлдэхүүн**

| | | Монгол |
|---|---|---|
| Ядуурлын олон хэмжигдэхүүнт индекс | | 0.065 |
| Олон хэмжигдэхүүнт ядууралд өртсөн хүн ам | Хамралт, хувь | 15.8 |
| | Гачигдлын Intensity, хувь | 41 |
| Олон хэмжигдэхүүнт ядууралд өртөх магадлалтай хүн амын эзлэх хувь | | 20.7 |

| | | Монгол |
|---|---|---|
| Наад зах нь нэг хэмжигдэхүүнээр гачигдалтай | Боловсрол, хувь | 6.8 |
| | Эрүүл мэнд, хувь | 19 |
| | Өдөрт 1.25 ам.доллараас (ХАЧП-аар) доогуур орлоготой хүн амын эзлэх хувь | 39.6 |
| Орлогын ядуурлын шугамаас доогуур хүн ам | Өдөрт 1.25 ам.доллараас (ХАЧП-аар) доогуур орлоготой хүн амын эзлэх хувь | 2.2 |
| | Үндэсний ядуурлын шугам, хувь | 36.1 |

Мөн илтгэлд дурьдсанаар манай улсын хүн амын 2.2 хувь нь өдөрт 1.5 ам.доллар хүрэхгүй орлоготой, 36.1 хувь нь үндэсний ядуурлын шугамаас доогоор орлоготой гэсэн дүн гарчээ.

**Жендерийн тэгш бус байдлын индекс**

Жендерийн тэгш бус байдлын индексийг (ЖТББИ) 138 орноор тооцож, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх мэдэл (empowerment), хөдөлмөрийн зах зээл дэх оролцооны хүйсийн тэгш бус байдлыг харуулжээ. Хүйсийн тэгш бус байдлын улмаас хүний хөгжилд хүрэх түвшний алдагдал бүс нутгуудад 17-85 хувь хүртэл хэлбэлзэж байна.



## Хүснэгт -23. Жендерийн тэгш бус байдлын индекс, бүс нутаг болон бусад ангилалаар

| | ЖТББИ Оноо | Эхийн эндэгдлийн түвшин | Өсвөр насны охидын төрөлтийн твшин | Парламентад суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь | Наад зах нь дунд боловсрол эзэмшсэн 25 ба түүнээс насны хүн амын эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эм | Эр |
| Монгол | 0.523 (57) | 46 | 16.6 | 4.2 | 83.0 | 81.8 |
| ***Хөгжингүй орнууд*** | | | | | | |
| ЭЗХАХБ-ын орнууд | 0.317 | 8 | 19.4 | 20.6 | 84.0 | 86.6 |
| ЭЗХАХБ-ын орнуудаас бусад | 0.376 | 16 | 11.2 | 18.1 | 70.4 | 72.1 |
| ***Хөгжиж буй орнууд*** | | | | | | |
| Арабын улсууд | 0.699 | 238 | 42.6 | 8.7 | 31.8 | 45.0 |
| Зүүн Ази, Номхон далайн орнууд | 0.467 | 126 | 18.1 | 19.8 | 48.2 | 61.4 |
| Европ болон Төв Азийн орнууд | 0.498 | 41 | 28.2 | 12.5 | 78.0 | 74.0 |
| Латин Америк, Карибын тэнгисийн орнууд | 0.609 | 122 | 72.6 | 17.5 | 51.3 | 52.7 |
| Өмнөд Ази | 0.739 | 454 | 65.0 | 10.4 | 27.4 | 49.1 |
| Сахар орчмын Африкийн орнууд | 0.735 | 881 | 122.3 | 17.3 | 23.9 | 38.1 |
| ***Хүний хөгжлийн түвшиний ангилал*** | | | | | | |
| Хүний хөгжил маш өндөр орнууд | 0.319 | 8 | 19.1 | 20.5 | 83.7 | 68.1 |
| Хүний хөгжил өндөр орнууд | 0.571 | 82 | 47.7 | 13.3 | 61.2 | 61.3 |
| Хүний хөгжил дундаж орнууд | 0.591 | 242 | 41.8 | 16.0 | 40.9 | 57.4 |
| Хүний хөгжил бага орнууд | 0.748 | 822 | 108.9 | 14.4 | 19.0 | 32.0 |
| Нэн буурай хөгжилтэй орнууд | 0.746 | 786 | 104.5 | 16.6 | 17.8 | 29.1 |
| Дэлхийн дундаж | 0.560 | 273 | 53.7 | 16.2 | 51.6 | 61.7 |

Үргэлжлэл

| | Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь | | Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг 15-49 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь | Төрөхийн өмнөх хяналтад хамрагдалтын хувь | Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | Эм | Эр | | | |
| Монгол | 70.0 | 79.5 | 66.0 | 99 | 99 |
| ***Хөгжингүй орнууд*** | | | | | |
| ЭЗХАХБ-ын орнууд | 65.5 | 80.1 | … | … | 99 |
| ЭЗХАХБ-ын орнуудаас бусад | 58.2 | 82.3 | … | 100 | 100 |
| ***Хөгжиж буй орнууд*** | | | | | |
| Арабын улсууд | 27.0 | 78.2 | 46.9 | 74 | 77 |
| Зүүн Ази, Номхон далайн орнууд | 70.1 | 64.5 | … | 91 | 91 |
| Европ болон Төв Азийн орнууд | 58.6 | 75.0 | 63.0 | 95 | 96 |
| Латин Америк, Карибын тэнгисийн орнууд | 55.3 | 83.3 | … | 95 | 91 |
| Өмнөд Ази | 37.2 | 84.2 | 53.8 | 70 | 45 |
| Сахар орчмын Африкийн орнууд | 63.8 | 82.3 | 23.6 | 73 | 48 |
| ***Хүний хөгжлийн түвшиний ангилал*** | | | | | |
| Хүний хөгжил маш өндөр орнууд | 65.3 | 80.2 | … | 100 | 99 |
| Хүний хөгжил өндөр орнууд | 52.7 | 79.5 | 66.3 | 95 | 96 |
| Хүний хөгжил дундаж орнууд | 54.7 | 84.1 | 68.4 | 84 | 74 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хүний хөгжил бага орнууд | 61.3 | 83.4 | 27.8 | 66 | 39 |
| Нэн буурай хөгжилтэй орнууд | 64.7 | 85.2 | 29.5 | 63 | 36 |
| Дэлхийн дундаж | 56.8 | 82.6 | … | 82 | 75 |

Манай улсын ЖТББИ 2010 онд 0.523 болж 57-р байранд орсон бол Зүүн Ази, Номхон далайн орнуудын жендерийн тэгш бус байдлын индекс 0.467 байгаа нь манай улсынхаас харьцангуй сайн үзүүлэлттэй буюу 0.056 пунктээр бага байна.

## 13. Дүгнэлт, санал зөвлөмж

### Дүгнэлт

Монгол Улсын 1990-2009 оны хоорондох өнгөрсөн 20 жилийн эдийн засгийн хөгжил, эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын бодит байдал, эдийн засгийн хөгжлийн ололт, алдаа дутагдал бүхэн нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих талаар Монгол Улсаас баримталж ирсэн стратеги, үе үеийн Засгийн газруудаас явуулсан эдийн засаг, нийгмийн бодлогын хэрэгжилтийн үр дүн гэж үзэж болно.

Монгол Улс анхнаасаа шилжилтийг “ цочир эмчилгээний” гэдэг стратеги баримтлан эхэлсэн бөгөөд түүний нийгмийн үр дагавар нь ихээхэн хүнд, ялангуяа хүн амын дунд ажилгүйдэл, ядуурал гүнзгийрэн тэлэх нөхцлийг бүрдүүлсэн. Шилжилтийг хэрэгжүүлсэн бусад улс орнуудын туршлагаас харахад xî¸ð ääõü çàãââð болох “ãðàäóàëèçì” áóþó “ үе øàòëàëò” çàãââðаар явсан орнууд эдийн засгийн өсөлт, хөгжлийн илүү өндөр амжилтанд хүрсэн байна. “ Цочир эмчилгээний” замаар яваад хүрсэн үр дүнг гадаадын зарим судлаачид тун хангалтгүй үнэлсэн байдаг. “ ÎÓÂÑ-èéí Ìîíãîëä òóëãàн ÿâóóëñàí ìºíãºíèé õàòóó áîäëîãî íü çýýëèéí ºíäºð õ¿¿ã áèé áîëãîñíîîðîî äîòîîäûí õºðºíãº îðóóëàëòûã àøèãëàõ ÿìàð÷ áîëîìæã¿é áîëãîæ, Ìîíãîëûí àæ ¿éëäâýðèéã ñ¿éðýëä îðóóëñàí “ ãýæ ìàíàé îðíû òóõàé õýä õýäýí íîì áè÷ñýí Keith Griffin áè÷æýý.[1]

Урт хугацаанд авч үзэхэд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн ерөнхий чиг хандлага тодорхой харагдаж байна. Гэхдээ эдийн засгийн өсөлт тогтворгүй, зарим жилүүдэд эргээд

[1] Keith Griffin, Poverty reduction in Mongolia, Asia Pacific Press, 2003

буурсан байна. Эдийн засгийн тууштай өсөлт үнэндээ 2004 оноос эхэлсэн, 2006-2008 онд эдийн засаг бүхэлдээ тэлж, өссөн харагдаж байна.

Монгол Улсын эдийн засгийн бүтэц ихэд хоцрогдсон, ДНБ –ний 47 хувийг хөдөө аж ахуй, олборлох үйлдвэрийн салбар гаргадаг, хөдөлмөрийн бүтээмж болон нэмэгдэл өртөг багатай салбар зонхилсон, үүнээсээ болоод манай эдийн засаг бүхэлдээ бүтээмж багатай, өрсөлдөх чадвар султай байна. Ялангуяа нэмэгдэл өртөг өндөртэй, эцсийн бүтээгдэхүүн гаргадаг боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувьд 2008 онд ДНБ –нд дөнгөж 6.1 хувь эзэлж байгаа нь тун чамлалттай байна.

1995 -2009 оны хооронд ДНБ –ний абсалют цэвэр өсөлтийн 32.6 хувь нь тээвэр, агуулахын аж ахуй,холбооны салбарт, 23.7 хувь нь уул уурхайн олборлох салбарт, 14.7 хуь нь хөдөө аж ахуйн салбарт, мөн 8.3-8.4 хувь нь үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагааны болон бөөний болон жижиглэн худалдааны салбарт бий болжээ. Эдгээр салбарууд нь дээрх хугацаанд ДНБ –ний цэвэр өсөлтийн 88,1 хувийг хангаж, түүний өсөлтөнд хамгийн их хувь нэмэр оруулсан салбарууд болж байна.

Үйлдвэрлэлийн функцээр эдийн засгийн өсөлтөнд үзүүлсэн ажиллах хүч, капиталын хүчин зүйлийн нөлөөг шинжилж үзэхэд хөрөнгө оруулалтын цэвэр өсөлтийн 1% -д ДНБ –ний цэвэр өсөлтийн 0.2 хувь, харин ажиллагсдын тооны цэвэр өсөлтийн 1% -д ДНБ –ний хэмжээ илүү мэдрэмжтэй, нөлөөтэй байгаа бөгөөд ДНБ –ний 1.38 хувийн цэвэр өсөлт харгалзаж байна.

Эдийн засгийн өсөлтийг хөдөлмөрийн бүтээмж болон ажиллагсдын тооны өсөлийн хүчин зүйлээр шинжилж үзэхэд 1990-2009 оны хооронд ДНБ –ний абсалют цэвэр өсөлтийн 67.1 % нь хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс, 32.9 % нь ажиллагсдын тооны өсөлтөөр бий болсон байна. Эндээс харахад 1990-2009 оны хооронд эдийн засгийн өсөлтийн 2/3 нь интенсив арга замаар буюу хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээс бий болжээ. ДНБ болон ажиллагсдын тооны хоорондын хамаарлыг регрессийн шинжилгээний аргаар судлахад хүчтэй хамааралгүй, хамаарлын хүч нь сулавтар байгааг 0,332 гэсэн коэффициент харууллаа.

Манай оронд ядуурлын анхны албан ёсны судалгаа эхэлсэн 1995 оноос хойшхи хугацаанд ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь 35- 38- ын

хооронд, ядуурал дорвитой буураагүй байсаар ирлээ. Өнгөрсөн 20 жилд эдийн засгийн өсөлт гарсан боловч ядуурал буураагүй нь эдийн засгийн өсөлт нь шууд ядуурлыг бууруулж, ард түмний амьдралыг сайжруулж чаддаггүй гэдэг дүгнэлтийг нотолж байна.

Амьжиргааны түвшинд нөлөөлсөн инфляцийн нөлөөллийг тооцох зорилгоор өрхийн мөнгөн орлогын өсөлтийг шинжилж үзэхэд 1990-2009 оны хооронд оны үнээрээ 367,8 дахин өссөний 99,6 хувь нь цэвэр үнийн өсөлтөөс харин 0,4 хувь нь орлогын бодит өсөлтөөс гарсан байна. Эндээс харахад Монгол Улсын хүн амын орлого, амьжиргааны түвшинд инфляци маш хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн нь тодорхой байна.

Харин инфляци ядуурлын шугамаар дамжин түүнд хэрхэн нөлөөлснийг авч үзэхэд инфляци нөлөөлөөгүй, харин ч эсрэгээр ядуурлын шугамыг ялангуяа 2005 оноос хойш тодорхойлж, зарлахдаа инфляцийн өсөлттэй уялдуулаагүй хэт өндрөөр тогтоосон байна. Энэ нь манай оронд ядуурал буурахгүй байгаа гол шалтгаан болжээ. Ядуурлын шугам бодит байдлаас өндөр, улам бүр өссөөр ирсэн тул ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрх улам нэмэгдэх нь аргагүй юм. 2000 оны ядуурлын шугамыг суурь болгосон Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшинг хэрэглээний үнийн өсөлтөөр засварлан тооцвол 2007 онд 33.7 мянган төгрөг, 2008 онд 2.3 дахин бага буюу 41.2 мянган төгрөгөөс хэтрэхээргүй гарч байна. Ийм учрас 2007-2008 онд явагдсан өрхийн нийгэм,эдийн засгийн судалгааны дүнд ядуурлын шугамыг 62,5 мянган төгрөгөөр авсан тул түүнийг дээрх хэмжээгээр засварлан авч, ядуурлын түвшинг улсын хэмжээнд болон бүс нутгаар дахин тооцох шаардлага гарч байна.

Ядуурал нь ажилгүйдэлтэй шууд холбоотой болох нь манай оронд 2002-2003 онд болон 2007-2008 онд явагдсан амьжиргааны түвшний судалгааны дүн харууллаа. 2002-2003 оны судалгаагаар ядуу бус хүмүүсийн дунд ажилгүйдэл харьцангуй бага 4,9 хувьтай байсан бол ядуу хүмүүсийн дунд 10,2 хувь буюу 2 дахин өндөр байв. Энэ байдал 2007-2008 оны судалгаагаар ч мөн давтагдсан байна. Сүүлийн судалгаагаар ядуучуудын дунд ажилгүйдэл 12,3 хувь байгаа нь ядуу бус хүмүүсийнхээс (6.2%) мөн л 2 дахин өндөр гарчээ. Ядуурлын хамралтын түвшин 2002-2003 оны судалгаагаар улсын дунджаар 36,1 хувь, өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхүүдийн хувьд 33,6 хувь байсан бол өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрхийн хувьд бүр өндөр 48,7 хувь байжээ. Энэ байдал 2007-2008 оны судалгаагаар л мөн давтагдаж, харин ядуурал газар авч, өрхийн тэргүүлэгч нь ажил

эрхэлдэггүй өрхүүдийн дунд ядуурлын хамрагдалт 54,4 хувьд хүрчээ. Энэ нь хүн амын ажилгүйдэл нь ядуурлын нэг гол шалтгаан гэдгийг дахин нотлож байна.

2002-2003 оны судалгаагаар ядуу өрхүүдийн сарын дундаж нийт хэрэглээ ядуу бус өрхүүдийнхээс 2,8 дахин доогуур, 2007-2008 оны судалгаагаар 1,9 дахин доогуур гарчээ. Эндээс өрхийн орлого, хэрэглээний түвшин амьжиргааны түвшинтэй шууд холбоотой нь харагдаж байна.

Манай оронд хүний хөгжлийн индекс 1990 –ээд оны дунд үеэс эхлэн тогтвортой өссөөр иржээ. Гэвч дэлхийн хүний хөгжлийн 2007-2008 оны илтгэлд Монгол Улс 2005 оны мэдээллээр дэлхийн 177 орноос 114 дүгээр байранд оржээ. Дэлхийн “Хүний хөгжлийн илтгэл 2010”-д үндэсний нийт орлогоор тооцсон Монголын хүний хөгжлийн индекс 2010 онд 0.622 болж, дэлхийн 169 орноос 100-р байр эзэлсэн нь Зүүн Ази, Номхон далайн хөгжиж буй орнуудын дунджаас 0.021 пунктээр, дэлхийн дунджаас 0.002 пунктээр доогуур байна.

Монгол Улс олон улсын хэмжээнд XXИ – ээр нэлээн хойгуур байр эзэлж байгаа нь уг индексийн тооцоонд ордог нэг хүн амд ногдох худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон ДНБ болон ҮНО -ний хэмжээ дэлхийн бусад оронтой харьцуулахад доогуур байгаатай холбоотой байна.

Хүний хөгжил, түүний дотор боловсролын түвшин болон ядуурлын хооронд тодорхой хамаарал байна. 2002-2003 оны өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгааны дүнгээр ядуу өрхүүдийн насанд хүрсэн хүн амын дотор дээд боловсролтой хүн дөнгөж 8,2 хувь эзэлж байхад ядуу бус өрхүүдийн хувьд энэ үзүүлэлт 91,6 хувь байна. Энэ нь хүний хөгжил,түүний дотор боловсролын түвшин өндөр байх нь ядуурлаас хол байх нөхцөл гэдгийг харуулж байна. Судалгаанаас ядуу өрхүүдийн дотор өндөр боловсролтой хүмүүсийн эзлэх хувь бага байхад ядуу бус өрхүүдийн дотор эсрэгээрээ өндөр боловсролтой хүмүүсийн эзлэх хувь харьцангуй их байгаа өрөнхий зүй тогтол ажиглагдаж байна.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол улсын эдийн засаг тодорхой амжилтанд хүрч, өсөлт гарсан хэдий боловч Дэлхийн банкнаас гаргадаг “Дэлхийн Хөгжлийн үзүүлэлтүүд-2007” эмхтгэлд тусгасан худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон нэг хүн амд ногдох үндэсний нийт орлогоороо Монгол Улсын дэлхийн 208 орноос 161 дүгээр байранд орж, дэлхийн бага орлоготой орнуудын жагсаалтаас гараагүй байна. Монгол Улс ДНБ -

ний нэг хүнд ногдох 1990 оныхоо түвшинд 2007 онд буюу 17 жилийн дараа хүрчээ. Энэ хугацаа нь манай орны эдийн засгийн хөгжлийн түүхэнд алдагдсан он жилүүд болж үлдлээ.

Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал нь сүүлийн жилүүдийн дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр үүссэн нөхцөл байдалтай ихээхэн холбоотой, хямралд өртсөн бусад улс орнуудын нэгэн адил эдийн засаг бүхэлдээ сэргэх зарим шинж тэмдэг ажиглагдах боллоо. Гэхдээ Монгол Улсын санхүүгийн секторын байдал сайжирч, макро эдийн засгийн тогтворжилт хангагдаж, эдийн засаг хямралаас бүрэн гарч, өндөр өсөлтөд хүртэл цаг хугацаа шаардагдах төлөвтэй байна. 2010 оны эхний 9 сарын байдлаар инфляцийн өсөлт оны эхнээс 8.3 хувьтай, мөнгөний нийлүүлэлт 2009 оны эхний 9 сарынхаас 45,2 хувь нэмэгдсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 13.3 байгаа нь үүнийг нотлоно.

Эдийн засгийн өсөлтийн гол онолуудын нөхцлөөс харахад Монгол Улсын хувьд хөгжиж байгаа бусад орнуудын адил технологийн хоцрогдол болон эдийн засгийн зардал ихтэй, хөрөнгө оруулалт нь үр ашиг багатай, байгаль, цаг уур нь хатуу ширүүн, далайд гарцгүй, хөгжингүй зах зээлээс хол байрлалтай, улс төрийн нөхцөл нь бохир, сонгуулийн амлалтаар эдийн засагтаа дарамт үзүүлдэг, институчлэл хөгжөөгүй, иргэдэд хууль адил тэгш үйлчилдэггүй зэрэг эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлүүд хүчтэй нөлөөтэй хэвээр байна. Эдгээр сөрөг нөхцлүүд он удаан жил оршсоор ирсэн нь Монгол Улс удтал эдийн засгийн хөгжлөөрөө хоцрогдож ирсэн шалтгаан байсан байж болно. Èõýíõи õºãæèëòýé îðíû ýäèéí çàñàã÷èä ýäèéí çàñãèéí õºãæèë ãýäýã áîë ÿäóóðàë, òýãø áóñ áàéäëûã áóóðóóëàõ, èë¿¿äýë àæèë ýðõëýëò, ýñâýë àæèëã¿éäëèéã áóóðóóëàõàä ÷èãëýñýí áîäëîãûã õýðýãæ¿¿ëæ, òîãòâîðòîé ýäèéí çàñãèéí ºñºëò, á¿òöèéí ººð÷ëºëò õèéõ ¿éë ÿâö ãýäýãò ñàíàë ¿íäñýíäýý íýãääýã. Энэ утгаараа Монгол Улсын хувьд ядуурал, ажигүйдлийг бууруулахаас эхлээд эдийн засгийн хөгжилд хүрэхэд олон шийдвэрлэгдээгүй асуудал оршсоор байна.

**Санал, зөвлөмж**

1. Улс орны урт хугацааны хөгжлийн бодлогыг эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийн нөлөөллийг багасгахад чиглүүлэхыг санал болгож байна. Үүнд технологийн хоцрогдлыг арилгах, өндөр технологыг нутагшуулах, хөрөнгө оруулалт хийх болон Засгийн газраас эдийн засгийн бодлогын шийдвэр гаргахдаа хөрөнгө оруулалтын үр

ашиг өндөр байх шалгуурыг тэргүүн ээлжинд баримтлах, улс төрийн хүчний явцуу эрх ашгаас урган гарсан болчимгүй шийдвэр нь эдийн засгийн хөгжилдөө дарамт саад болдог одоогийн практикийг халах шаардлагатай.

2. Улс орны урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох чиглэлийг тууштай баримтлахыг санал болгож байна. Манай орны эдийн засагт хөдөө аж ахуй, уул уурхайн салбар зонхилсон одоогийн бүтцийг яваандаа өөрчлөх нь хөдөлмөрийн бүтээмж болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл гэж үзэж байна.

3.Эдийн засгийн хөгжил, өсөлтийн бодлогыг ÿäóóðàë, àæèëã¿éäëèéã áóóðóóëàõàä илүүтэй ÷èãëүүлэн õýðýãæ¿¿ëæ, òîãòâîðòîé ýäèéí çàñãèéí ºñºëò, á¿òöèéí ººð÷ëºëò õèéõэд чиглүүлэх шаардлагатай байна.

4. Эдийн засгийн өсөлт гарч байгаа боловч ядуурал буурахгүй байгаа тул ядуурлыг үр дүн олигтой авчраагүй бэлэн мөнгө тараах, нийгмийн хавтгайруулсан халамжийг нэмэгдүүлэх уламжлалт аргаар бус, “ажил хийснээр ядуурлаас гарах“ шинэ стратеги , бодлогыг баримталж, ядуурлыг бууруулахыг санал болгож байна. Нийгмийн халамжийг хүн амын эмзэг хэсэг, зорилтот бүлэгт чиглүүлэхэд илүү анхаарснаар ядуурлыг бууруулахад илүү түлхэц болно гэж үзлээ.

5. Олон улсын туршлагаас харахад эдийн засгийн эрчимтэй өсөлт нь зөвхөн зохистой хөдөлмөрөөр дамжин ядуурлыг бууруулдаг бөгөөд энэ нь бүтээмж өндөртэй ажлын байр шинээр бий болгосноор хэрэгждэг байна. Ийм учраас бүтээмж өндөртэй ажлын байрыг олноор нь шинээр бий болгох, түүнийг урамшуулах хууль эрх зүйн орчинг яаралтай бий болгохын санал болгож байна. Тухайлбал, олон жил ярьж байгаа ажил олгочдын төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг багасагах асуудлыг шийдэх цаг болсон. Монголын өнөөгийн нөхцөлд ажил олгогчдоос төлдөг ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэл нь хэт өндөр байгаагаас тэд үнэндээ ажлын шинэ байр бий болгох хүсэл сонирхолгүй байсаар ирсэн. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд ажлын байр шинээр олноор нь бий болгосны төлөө харин ч татварын хөнгөлөлт эдэлдэг байх шаардлагатай.Ийм нөхцөлд ажлын байр олноороо нэмэгдэж, ядуурал бодитой буурах болно.

6. Эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулахад улс орныг үйлдвэржүүлэх стратеги шийдвэрлэх ач холбогдолтойг хоцрогдсон орноос хөгжил дэвшилд хүрсэн орнуудын туршлага бэлээхэн харуулсан. Үйлдвэржүүлэлтийн бодлогыг тууштай, эрчимтэй, төрөөс зориуд дэмжих арга замаар хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэхдээ одоогийнх шиг дан ганц жижиг, дунд үйлдвэрт илүү анхаарах биш, харин томоохон үйлдвэрийн цогцолборуудыг байгуулж, харин тэднийг дэмжсэн жижиг, дунд үйлдвэрийг тойруулан хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Жижиг, дунд үйлдвэрүүд нь ихэвчлэн зах зээл нь баталгаатай томоохон үйлдвэрүүдийг дагаж амьдардаг дэлхийн жишгийг бид анхаарах ёстой.

7. 2007-2008 онд явагдсан өрхийн нийгэм,эдийн засгийн судалгааны дүнд ядуурлын шугамыг 62,5 мянган төгрөгөөр буюу өмнө тооцсон шугамаас харьцангуй өндөр, инфляцийн өсөлтөөс 2,3 дахин давсан шугамаар авсан тул түүнийг дээрх хэмжээгээр засварлан авч, ядуурлын түвшинг улсын хэмжээнд болон бүс нутгаар дахин тооцохыг санал болгож байна.

**Ашигласан ном, материалууд**


1. Development economics
2. N. Gregory Mankiw, Drinciples of Economics
3. Keith Griffin, Poverty and the Transition to a Market Economy in Mongolia
4. Keith Griffin, Poverty reduction in Mongolia, Asia Pacific Press, 2003.
5. ADB, Mongolia Country Poverty Assessment (CPA), 2009.
6. Joseph E. Stiglitz, Globalization and its discontents. 2003.
7. ×. Óëààí, “Àêòóàëüíûå âîïðîñû ïåðåõîäà Ìîíãîëèè ê ðûíî÷íûì îòíîøåíèåì è èõ ñîöèàëüíî-ýêîíîìè÷åñêèå ïîñëåäñòâèÿ,” Óëààíáààòàð, 2005.
8. Монгол эдийн засаг: Øèëæèëòèéí ýäèéí çàñãèéí ãàðûí àâëàãà. ÌÓÈÑ-èéí Ýäèéí çàñãèéí ñóðãóóëü, ÅÕ/ÒÀÑÈÑ õºòºëáºð, Ìàí÷åñòðèéí èõ ñóðãóóëü,УБ, Ìàí÷åñòåð, 1999 он
9. Б.Батмөнх, Øèëæèëòèéí ¿åèéí ìàêðî ýäèéí çàñãèéí îëîí óëñûí íèéòëýã òóëãààìàñàí àñóóäëóóä ñýäýâò ñóóðü ñóäàëãààíû òàéëàí, 2007 он.
10. ҮСХ, Дэлхийн банк,НҮБ-ын хөгжлийн Хөтөлбөр, Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний 2002-2003 оны түүвэр судалгааны үндсэн тайлан, 2004
11. Үндэсний Статистикийн Хороо, Дэлхийн Банк :Монгол дахь ядуурлын дүр төрх, Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгааны дүн, 2009 он
12. Монгол Улсын 2007 оны Хүний хөгжлийн илтгэл: Хөдөлмөр эрхлэлт,ядуурал
13. ҮСГ, АХБ, Ажиллах хүчний 2002-2003 оны судалгааны үндсэн тайлан,2004 он
14. Монгол Ӧлсын статистикийн эмхтгэл , 2000, 2003,2005,2007,2009 îí
15. UNDP, Human Development Report 2007/2008, Fighting climate change: Human solidarity in a divided world, 2007.
16. “Human Development Report-2010” – UNDP